

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Хэлэлцсэн асуудал</b>	<b>Хуудасны дугаар</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-18
<b>2.</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	19-88
	<b>1. Ажлын хэсэг байгуулах тухай /Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий/</b>	21-29
	<b>2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	29-82
	<b>3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 09 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан/</b>	82-88

## **ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

***Хоёр.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, Хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал нар цахимаар оролцов.

Хуралдаанд Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн

байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

*Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Амарсайхан, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Г.Ганболд, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин нарын гаргасан, цаашид “ажлын хэсэг” гэх.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 5  
Бүгд: 14  
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“нэгж” гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог;

4.1.2.“нэгжийн удирдлага” гэж нэгж дэх нутгийн өөрийн удирдлага болон төрийн удирдлагыг хэрэгжүүлж буй тогтолцоо, үйл ажиллагааг;

4.1.3.“нутгийн өөрийн удирдлага” гэж иргэд шууд эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуульд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.4.“нэгж дэх төрийн удирдлага” гэж бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.5.“нутгийн өөрөө удирдах байгууллага” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн шууд оролцоо бүхий иргэдийн Нийтийн Хурлыг;

4.1.6.“орон нутгийн чиг үүрэг” гэж хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг;

4.1.7.“орон нутгийн эрх хэмжээ” гэж нэгжийн удирдлагад хуулиар олгосон чиг үүрэг, нутгийн өөрийн удирдлага болон нэгжийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг;

4.1.8.“төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг” гэж нэгжийн удирдлагад төрөөс шилжүүлсний дагуу түүний нэрийн өмнөөс хэрэгжүүлэх чиг үүргийг;

4.1.9.“орон нутгийн өмч” гэж орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эд хөрөнгийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

3.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“6 дугаар зүйл.Аймаг**

6.1.Аймаг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сумдын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг нар хариулж, тайлбар хийв. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

## **“7 дугаар зүйл.Сум**

7.1.Сум нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд үзүүлэх хуульд заасан үйлчилгээг зохион байгуулах үндсэн нэгж мөн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13  
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

## **“9 дүгээр зүйл.Нийслэл**

9.1.Нийслэл нь төрийн дээд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, дүүргүүдийн үйл ажиллагааг зохицуулах, иргэдэд хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн.

9.2.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлыг хуулиар тусгайлан тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Нэгжийг өөрчлөх асуудлыг санаачлахдаа өмнө нь иргэдэд үзүүлж байсан үйлчилгээг дордуулахгүй байх зарчмыг баримтална.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн нэрийн “зааг” гэсний дараа “нэгжийн нэр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 9  
Бүгд: 12  
25.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:

“14.3.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэрийг төрийн албан ёсны хэлээр нэрлэж, хаягийг монгол хэл бичгээр хаяглана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 9  
Бүгд: 12  
25.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Л.Энх-Амгалан:** 7.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.5, 15.1.6 дахь заалт нэмэх:

“15.1.5.орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн нэгжийн хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавхыг харгалзан хөрөнгө хуваарилна;

15.1.6.хуульд заасан үндэслэл, журмын дагуу концесс болон үнэт цаас гаргах асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Ж.Батсуурь, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан, 15.1.6-д “дүүрэг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 8  
Бүгд: 12  
33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Л.Энх-Амгалан:** 8.Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“18 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч**

18.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь өмчтэй байна.

18.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга тус тус хэрэгжүүлнэ.

18.3.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах эрхтэй.

18.4.Орон нутгийн өмчийн харилцааг тусгайлан хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Тогтохсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“20 дугаар зүйл.Орон нутгийн чиг үүрэг**

20.1.Орон нутгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

- 20.1.1.орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт;
- 20.1.2.орон нутгийн өмчийн удирдлага;
- 20.1.3.орон нутгийн төсөв, татвар, төлбөр, хураамж;
- 20.1.4.орон нутгийн сан;
- 20.1.5.орон нутгийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр;
- 20.1.6.орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй;
- 20.1.7.хүн амын унд, ахуйн хэрэгцээний ус хангамж;

20.1.8.худалдаа, үйлчилгээний зохицуулалт;  
20.1.9. орон сууц, нийтийн аж ахуй;  
20.1.10.орон нутаг дахь нийтийн тээвэр;  
20.1.11.суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол;  
20.1.12.гудамж, талбайн нэр, хаягжилт;  
20.1.13.хөшөө дурсгалын зохицуулалт;  
20.1.14.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж;

20.1.15.орон нутгийн аялал жуулчлалын бодлого, менежмент;  
20.1.16.хог хаягдлын менежмент;  
20.1.17.оршуулгын газрын зохицуулалт;

20.1.18.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

20.1.19.гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу;

20.1.20.орон нутгийн цэвэрлэх байгууламж;  
20.1.21.орон нутгийн зам, гүүр;  
20.1.22.суурин газрын гэрэлтүүлэг;  
20.1.23.бэлчээрийн ашиглалт, хамгаалалт.

20.2.Хуулиар зохих нэмэлт оруулсны үндсэн дээр орон нутгийн чиг үүргийг нэмэгдүүлж болно.

20.3.Нутгийн өөрөө удирдах байгууллага энэ зүйлийн 20.1-д заасан чиг үүргээс гадна Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан нутаг дэвсгэрийнхээ тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Н.Энхболд нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг нар хариулж тайлбар хийв. Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ж.Ганбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан,

**“25 дугаар зүйл.Дүүргийн чиг үүрэг**



25.1.10.дүүргийн ерөнхий төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг нэмж, 21.15-д хот, суурингийн газрын авто зогсоолын байршил, арчилгаа гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар саналаа тайлбарлаж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 6  
Бүгд: 12  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энх-Амгалан:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Л.Энх-Амгалан:** 10.Төслийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.6.Нутаг дэвсгэрийн иргэдийн болон хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 3 өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт 5 өрх тутмаас, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хэсэг тус бүрийн 20 өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг хуралдаан болохоос ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө тухайн баг, хорооны оршин суугчдад мэдээлэх бөгөөд хуралдах байршил, цагийг тусгасан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар үг хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, ажлын хэсгийн гишүүн, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 33 дугаар зүйлд 33.7 дахь хэсэг нэмэх.

“33.7.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн дараах иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг сум, дүүргийн Засаг дарга шинээр томилогдсоны дараа зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.6.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.

*Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн мөрдөнө.*” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, С.Амарсайхан нар үг хэлж, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 7  
Бүгд: 11  
36.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

13.Төслийн 42 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“42 дугаар зүйл.Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

42.1.Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

42.1.1.Төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашиглах;

42.1.2.өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх.

*Тайлбар: Энэ заалтыг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн мөрдөнө.*” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.6.Улс төрийн нам, эвсэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй.

*Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн мөрдөнө.*” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 48 дугаар зүйлийн 48.1.4, 48.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.1.4.ээлжит сонгуулийн дүнг өргөн мэдүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн шатны сонгуулийн хороо иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг зарлан хуралдуулна. Анхдугаар хуралдааныг хуралдаанд хүрэлцэн ирсэн насаар хамгийн ахмад сонгогдсон төлөөлөгч даргална;

48.1.5.анхдугаар хуралдаанаас бусад хуралдааныг тухайн Хурлын дарга хуралдаан эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна. Хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор төлөөлөгчдийн аль нэг нь удирдана;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Тухайн Хурал өөрийнх нь чиг үүрэг, бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжүүлэх боломжгүй, санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга өөрийн санаачилгаар, эсхүл дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдын даалгаснаар холбогдох шийдвэрт бүхэлд нь

буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“53.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулсан зохицуулах үүрэг бүхий 5-7 хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 55 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“55 дугаар зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгох**

55.1.Сонгуулийн дүнгээр байгуулагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаар Хурлын даргыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

55.2.Тухайн Хурлын төлөөлөгч Хурлын даргад өөрийн болон бусад төлөөлөгчийн нэр дэвшүүлэх эрхтэй. Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад нам, эвслийн бүлэг нэр дэвшүүлж болно.

55.3.Хурлын даргыг сонгох асуудлаар нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын санал авсан хүнийг Хурлын даргаар сонгогдсонд тооцно.

55.4.Нэр дэвшигчийн аль нь ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг хоёр дахь санал хураалтад оруулах бөгөөд тэдгээрийн хэн нь ч олонхын санал аваагүй бол энэ зүйлд заасан журмаар Хурлын даргад дахин нэр дэвшүүлнэ.

55.5.Хурлын төлөөлөгчид санал хураалтад оролцохдоо зөвхөн нэг хүний төлөө санал өгөх бөгөөд нэр дэвшигч өөрөө санал хураалтад оролцох эрхтэй.

55.6.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга орон тооны байна.

55.7.Хурлын даргыг нөхөн сонгоход энэ зүйлд заасан журмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“58.5.Засаг даргад нэр дэвшүүлэх ажиллагааг дараах журмаар явуулна:

58.5.1.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, сонгуулийн дүнгээр олонхын суудал авсан нам, эвслийн бүлэг, иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтарч энэ хуулийн 58.3, 58.4-т заасан шаардлага хангасан хүнийг нэр дэвшүүлэхээ санал гаргана.

Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 58.3-т заасан шаардлага хангасан хүнийг тухайн Хуралд санал болгож болно;

58.5.2.энэ хуулийн 58.5.1-д заасан хүний талаар санал хураалт явуулж, Хуралд оролцсон иргэдийн, түүнчлэн нийт төлөөлөгчдийн олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлнэ;

58.5.3.хэрэв санал хураалтаар хэн ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүний талаар дахин санал хурааж олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлнэ;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.15-д заасны дагуу хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн*

*Б.Пүрэвдоржийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, “Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 58.3-т заасан шаардлага хангасан хүнийг тухайн Хуралд санал болгож болно.” гэснийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 9  
Бүгд: 11  
18.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Л.Энх-Амгалан:** 21.Төслийн 74 дүгээр зүйлийн 74.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“74.1.2.шаардлагатай гэж үзвэл харьяалагдах нутаг дэвсгэрийн салбарын болон салбар хоорондын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхдээ тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзан Засаг даргын саналыг тусган хамтарсан шийдвэр гаргаж, биелэлтийг зохион байгуулах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 75 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“75 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын харилцаа**

75.1.Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор нэгж хоорондоо доор дурдсан хэлбэрээр харилцана:

75.1.1.бодлого, үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох;

75.1.2.нийтийн эрх зүйн гэрээ байгуулах;  
75.1.3.харилцан туслалцаа үзүүлэх;  
75.1.4.төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх;  
75.1.5.харилцан туршлага солилцох;  
75.1.6.хууль тогтоомжид заасан бусад хэлбэрээр харилцах.

75.2.Энэ хуулийн 75.1-д заасан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх явцад Засаг хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.21-д заасны дагуу ажлын хэсгийн гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** 1.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “бүхий” гэсний дараа “нийтлэг” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “хэрэгжүүлэх” гэсний дараа “үйл ажиллагааг дэмжих” гэж, 60 дугаар зүйлийн 60.1.10 дахь заалтын “ашиглах,” гэсний дараа “хууль” гэж, 62 дугаар зүйлийн 62.1.20 дахь заалтын “аймаг” гэсний өмнө, 65 дугаар зүйлийн 65.1.15 дахь заалтын “нийслэл” гэсний өмнө “энэ хуульд заасан үндэслэлээр” гэж, 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн “нутаг дэвсгэрийн” гэсний дараа “иргэн,” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “дамжуулж” гэснийг “уламжлан” гэж, 2 дугаар зүйлийн “нэгжийн” гэснийг “нэгж, түүний удирдлагын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “засаг захиргааны” гэснийг “хуульд заасан” гэж, мөн зүйлийн 11.2 дахь хэсгийн “хорооны иргэдийн Нийтийн Хурал” гэснийг “дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтын “зоригийн илэрхийлэл байх,” гэснийг “зоригийг илэрхийлж,” гэж, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “нийгмийн” гэснийг “хуульд заасан” гэж, 16 дугаар зүйлийн гарчгийн “төсвийн эрх мэдэл” гэснийг “төсөв” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “тогтооно” гэснийг “тогтоож, журмын хэрэгжилтэд хяналт тавина.” гэж, 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн “үйл ажиллагаатай холбоотой” гэснийг “үйл ажиллагааны зохион байгуулалтын” гэж, 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсгийн “мөрдөгдөнө” гэснийг “хэвээр үлдээнэ” гэж, 61 дүгээр зүйлийн 61.1.8 дахь заалтын “Засгийн газрын” гэснийг “төрийн” гэж, мөн зүйлийн 61.1.9 дэх заалтын “20 дугаар зүйлийн 20.6-д” гэснийг “20 дугаар зүйлд” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “талаар” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсгийн “аравт,” гэснийг тус тус, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 37 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд” гэснийг, 54 дүгээр зүйлийн 54.1.6 дахь заалтын “асуудлыг Хуралд оруулж шийдвэрлүүлэх” гэснийг, 58 дугаар зүйлийн 58.8 дахь хэсгийн “иргэдийн” гэснийг, 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсгийн “Засаг даргыг” гэснийг, 74 дүгээр зүйлийн 74.1.4 дэх заалтын “хүч,” гэснийг, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “төв” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 2  
Бүгд: 12  
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Ажлын хэсгээс гаргасан найруулгын саналаар санал хурааж дууслаа.*

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

- Монгол Улсын татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй болно.

*Хоёр. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Хотын албан татварын тухай анхдагч хуулийн төслийг 2021 оны эхний хагаст багтаан боловсруулж, өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	6
Бүгд:	12



50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энх-Амгалан:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 3

Бүгд: 12

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

## **ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

***Хоёр.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийг танхимд орж ирэхийг урьж байна. Ажлын хэсгийг танилцуулъя.

Д.Ганзориг Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Ц.Товуусүрэн Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан, Р.Хатанбаатар Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан, Н.Лувсанжав Монгол Улсын гавьяат хуульч, А.Бямбажаргал Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, Хууль зүйн ухааны доктор гэсэн ажлын хэсэг хүрэлцэж ирсэн байна.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулна.

**Ж.Сүхбаатар:** Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Бямбацогт, Х.Нямбаатар, Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Д.Лүндээжанцан, Н.Амарзаяа, Д.Ганболд, Ж.Батзандан нараас 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдөр дээрх хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, ажлын хэсгийн дэмжсэн 56 зарчмын зөрүүтэй, найруулгын 4 багц саналын томъёоллоор санал хураалт явуулан хуулийн төслийн зүйл бүрээр санал хурааж чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар Байнгын хорооны дэмжсэн 53, Байнгын хорооны дэмжээгүй 6, найруулгын 1 багц санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны дэмжсэн 6, найруулгын 1 саналыг бэлдсэн.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдөр 5 хоногийн, 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр 3 хоногийн завсарлагыг тус тус чуулганы нэгдсэн хуралдаанаас авсан болно.

Улсын Их Хурлын 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль явагдсантай холбогдуулан зарим зарчмын зөрүүтэй саналыг эргэн харах, сайжруулах нөхцөл шаардлага үүссэн гэж үзэн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин үргэлжлүүлэн явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн тул хуулийн төслийг Байнгын хороонд буцаасан.

Ажлын хэсэг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн 53, Байнгын хорооны дэмжээгүй 6, найруулгын 1 багц санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн Байнгын хорооны дэмжсэн 6, найруулгын 1 бэлдсэн саналаас үүссэн нөхцөл байдлыг харгалзан зайлшгүй сайжруулах шаардлагатай гэж 22 зарчмын зөрүүтэй, 1 багц найруулгын санал болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн талаарх 1 зарчмын зөрүүтэй саналыг нэмж гүйцээн боловсрууллаа.

Бусад саналыг 2020 оны 8 дугаар сарын 19-ний Байнгын хорооны хуралдаанд дэмжсэн томъёоллоор чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар тооцлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс боловсруулан оруулж байгаа зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Ж.Сүхбаатар гишүүнд баярлалаа.

Одоо хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Одоо ингээд шууд санал хураалт хийгээд явчихна шүү дээ. Тийм ээ.

Гишүүд ээ, одоо нийт 81 зүйлтэй ийм санал хураалт байгаа. Тийм учраас гишүүд танхимдаа байж байгаад зүйл зүйлээр санал хураалт хийнэ.

Ийм байгаа юм байна. Гишүүд ээ. Нийт 81 зүйлтэй. Тэгээд эндээс Улсын Их Хурлын даргын зүгээс гүйцээн боловсруулах чиглэл өгсөн ийм 22 зарчмын зөрүүтэй саналын томьёолол байгаа юм байна. Тийм ээ.

Тийм учраас энэ 22 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгая гэдэг ийм саналыг ажлын хэсгээс гаргасан юм байна. Тийм. Бусдыг нөгөө 8 сарын 19-нд чуулганаар хэлэлцүүлэг хийсэн. Шийдвэрлэсэн энэ санал хураалтаар үргэлжлүүлээд явъя гэж байгаа юм байна шүү дээ. Тийм ээ.

Тэгвэл ажлын хэсгийн гишүүдийн гаргасан Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу гүйцээн боловсруулсан энэ 22 зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт хийлгэе гэсэн томьёоллоор санал хураалт хийе. Гишүүд ээ.

Одоо санал хураалт машинаараа. Санал хураалт.

**Г.Занданшатар:** Санал хураалтыг гар өргөж явуулъя гээд санал хураасан шүү дээ.

**Л.Энх-Амгалан:** Түрүүний асуудал байхгүй юу. Түрүүний асуудал дууссан.

Одоо энэ асуудал дээр энэ автоматаар санал хураалт хийж байгаа.

14 гишүүн оролцож, 10 гишүүн зөвшөөрч, 71.4 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Ингээд энэ санал дэмжигдсэн учраас энэ 22 зүйлээр санал хураалт хийх юм байна. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор.

Одоо ингээд зүйл бүрээр нь санал хураалт хийнэ шүү дээ. Тийм ээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгийн санал байгаа юм байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг хасах. Санал хураалгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Амарсайхан, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Г.Ганболд, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалт.

14 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 64.3 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгийн бас зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна.

2.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“нэгж” гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог ;

4.1.2.“нэгжийн удирдлага” гэж нэгж дэх нутгийн өөрийн удирдлага болон төрийн удирдлагыг хэрэгжүүлж буй тогтолцоо, үйл ажиллагааг;

4.1.3.“нутгийн өөрийн удирдлага” гэж иргэд шууд эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага энэ хуульд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа;

4.1.4.“нэгж дэх төрийн удирдлага” гэж бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.5.“нутгийн өөрөө удирдах байгууллага” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн шууд оролцоо бүхий иргэдийн Нийтийн Хурлыг;

4.1.6.“орон нутгийн чиг үүрэг” гэж хуульд заасны дагуу нутгийн өөрийн удирдлагад тусгайлан олгосон, нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн шинжтэй асуудлыг;

4.1.7.“орон нутгийн эрх хэмжээ” гэж нэгжийн удирдлагад хуулиар олгосон чиг үүрэг, нутгийн өөрийн удирдлага болон нэгжийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг;

4.1.8.“төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг” гэж нэгжийн удирдлагад төрөөс шилжүүлсний дагуу түүний нэрийн өмнөөс хэрэгжүүлэх чиг үүргийг;

4.1.9.“орон нутгийн өмч” гэж орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эд хөрөнгийг.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд ээ.

13 гишүүн оролцож, 11 гишүүн зөвшөөрч, 84.6 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

**Г.Занданшатар:** Л.Энх-Амгалан дарга аа. Үг байгаа шүү.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Нэг залруулж, тодруулж хийх санал байна. Саяны хураагдаж байгаа саналууд бол ажлын хэсгээс гүйцээн боловсруулсан, дахин боловсруулсан саналууд. Үүнийг ажлын хэсгийн даргын хэлснээр Байнгын хорооны дэмжсэн 52 санал. Санал хураагдаж амжаагүй байсан 22 саналыг гүйцээн боловсруулаад, 6 саналыг засаж янзлаад оруулж ирж байгаа гэж.

Энэ анхны хэлэлцүүлэг учраас Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн гэж түрүүн Байнгын хороон дарга хэлснийг залруулж байна.

Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн саналууд энэ биш шүү. Энэ бол ажлын хэсгийн түвшиндөө, Байнгын хорооны түвшиндөө ахиж боловсруулаад оруулж ирж байгаа. Анхны хэлэлцүүлэг л үргэлжлээд явж байгаа.

Гүйцээн боловсруулах чиглэл чинь анхны хэлэлцүүлгийн дараа, чуулганаар орсны дараа. Протоколд тэмдэглүүлэхгүй бол.

**Л.Энх-Амгалан:** Х.Нямбаатар гишүүн.

Ер нь юу юм байна л даа. Сая нөгөө эхний хэлэлцүүлэг Байнгын хороогоор хэлэлцүүлэгдээд санал хураалт хийгээд 8 сарын 19-нд явуулсан. Энэ үед нөгөө орон нутгийн сонгууль бас ойртсон байсан. Ингээд орон нутгийн сонгуультай бас уялдуулж зарим энэ заалтуудыг бас гүйцээн боловсруулах ийм шаардлага үүссэн учраас ажлын хэсгийн гишүүд бас энэ томьёоллоор гүйцээн боловсруулсан ийм саналын томьёоллууд байгаа юм байна.

Х.Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль гэдэг бол бас одоо манай нийгмийн гол суурь харилцааг зохицуулж байгаа ийм хууль.

Энэ 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд одоо Улсын Их Хурал тодорхой хууль тогтоомжуудыг шинэчлэх ийм үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд хийгдэж байгаа хууль тогтоомжийн шинэчлэлүүдийн нэг бол энэ яах аргагүй мөн.

Ажлын хэсэгт орон нутгийн ажил, амьдралыг мэддэг олон хүмүүс энэ ажлын хэсгийг бүрдүүлж. Гэхдээ энэ анхны хэлэлцүүлэг учраас би ажлын хэсгийн гишүүдийг хоёр, гурван зүйлийг дахиад дараагийн хоёрдугаар хэлэлцүүлгээс өмнө нэг хараач ээ гэж хэлэх гэж байгаа юм.

Сая 4 дүгээр зүйл дээр санал хураачихлаа. 4 дүгээр зүйлийг бүхэлд нь шинэчлэн найруулж ингэж санал хураалгаж байх шиг байна. Ажлын хэсэг.

Энэ төслийн 19, 20 дээр орон нутгийн чиг үүргийг тогтоох зарчим. 20 дээр орон нутгийн чиг үүргүүдийг ингээд зааглаж өгч л дээ.

Тэгээд энд ерөөсөө үүнээс хойш ингээд аймгийн чиг үүрэг, сумын чиг үүрэг, нийслэлийн чиг үүрэг, дүүргийн чиг үүрэг, баг, хорооны чиг үүргүүдийг тус тусад нь зааглахыг одоо энэ төслөөр оролдож ингэж зохицуулсан байна.

Энэ дээр дандаа нийтлэг тийм үлгэр талдаа юмнууд байна. Ялангуяа манай эрдэмтэд үүнийгээ нэг эргэж харж өгөөч ээ. Энд өмчийн зааг ялгааг төдийлөн энэ төсөл дээр бас ингээд тодорхой болгож өгөөгүй байна.

Тэгээд сумын чиг үүрэг гэхэд сумын чиг үүрэг гэж ийм зүйл байна. Дүүргийн чиг үүрэг гэж дүүргийн хөгжлийн үндсэн бодлого, төлөвлөлтийг хариуцна. Дүүргийн өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад хяналт тавина гэсэн ийм ерөнхий нийтлэг зүйлүүдээ л бичсэн байна.

Бид ч гэсэн би өөрөө бас орон нутагт ажиллаж байсан. Энэ хоёр өмчийн зааг олддоггүй. Нийслэлийн өмч гэж яг юуг хэлдэг юм. Дүүргийн өмч гэж яг юуг хэлдэг юм. Энэ заагийг эсвэл энэ дээр дараагийн хэлэлцүүлэг дээр маш тодорхой болгож өгөөч. Энэ нь сумын өмч, энэ нь аймгийн өмч. Энэ хоёрынхоо зааг ялгааг гаргаад. Энэ зааг ялгаан дээр суурилж энэ орон нутгийн чиг үүргүүдийн зааг ялгаа илүү их тов тодорхой гарна л гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн минь нэг эргэж харж өгөөч ээ.

Хоёр гэвэл, бид энэ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийн өөрийнх нь онцлог бол бид яг Үндсэн хуулийнхаа суурь зарчим дээр суурилсан нөгөө нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай орон нутагт хослуулах үндсэн дээр тэр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага тогтоно гэдэг тэр суурь зарчим руугаа илүү тодорхой зохицуулалтыг гаргаж ирвэл яасан юм бэ гэсэн ийм хоёр үг хэлэх гэсэн юм.

**Л.Энх-Амгалан:** Х.Нямбаатар гишүүн санал хэллээ. Ажлын хэсгийнхэн дараагийн.

Ж.Сүхбаатар гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

**Ж.Сүхбаатар:** Сая Х.Нямбаатар гишүүний хэлж байгаа юм бол хойшоо гарах асуудлууд дээр шууд байр сууриа хэлээд явчихлаа.

Яах вэ. Тэр янз бүрийн чиг үүрэг нь яг мөн үү, биш үү гээд л ингээд. Эсвэл тэнд тийм чиг үүрэг байх ёстой юу гэдэг асуудал гардаг. Тэр өмчийн асуудал тэртээ тэргүй Орон нутгийн өмчийн тухай хууль гэж гарна шүү дээ. Аль нь суманд очих юм.

Энд бол ямар ч гэсэн чиг үүрэг сум, сумын өмчийн ашиглалт гэдэг юм уу, хамгаалалт гэдэг юм уу. Энэ болгон чинь ингээд байна гэдэг ерөнхий тэр ажлынх нь тэр чиглэлүүдийг нь л зааж өгч байгаа шүү дээ. Түүнээс энэ дотор яг одоо тэр Засаг даргын бүрэн эрх, иргэдийн Хурлын бүрэн эрх гээд энэ чиг үүрэгт нь яг тэр аймаг, суманд нь шууд орж байгаа биш. Энэ чиг үүргээс урган гараад бусад тэр асуудлууд нь бусад хуулиудаараа ингээд тодорхой болох ёстой ийм байгаа.

Одоо эргэж харах юу байх вэ. Одоо тэгээд нэлээн ажилласан. Санал, онол авах зөндөө хугацаа байсан. Одоо яг ингээд тодорхой санал дээрээ л саналаа хураагаад л.

Х.Нямбаатар гишүүн тодорхой тэр дүүргийн чиг үүрэг юм уу, нийслэлийн чиг үүрэг дээр очихоор энэ нь болохгүй байна, тэр нь болж байна гэдгээ өөрөө хэлээд явах байх л даа. Түүнээс одоо бол энэ чинь бид анхны хэлэлцүүлгээ ингээд хоёр дахь удаагаа үндсэндээ үргэлжлүүлээд хийж байгаа шүү дээ.

**Л.Энх-Амгалан:** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 6 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол байгаа юм байна.

3.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“6 дугаар зүйл.Аймаг**

6.1.Аймаг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сумдын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн.”

Санал гаргасан Ажлын хэсэг.



**Г.Занданшатар:** Үг байна.

**Л.Энх-Амгалан:** Нэрээ өгөөрэй. Кнопоо дараад нэрээ өгөөрэй.

Ж.Ганбаатар гишүүн. Г.Занданшатар дарга байгаа юм байна. С.Амарсайхан гишүүний нэрийг бас оруулаарай.

Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа.

Энэ 6 дугаар зүйлийн эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах эрхтэй гэдгийг ажлын хэсгийн ахлагч ч юм уу, манай дэд ажлын хэсгийнхэн бас нэг дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч ээ гэж.

Ер нь ямар эдийн засгийн болоод. Яг эдийн засаг гэдэг дээр нь тогтож асууж байгаа юм. Эдийн засаг гэдэг дээр нь. Нийслэл, дүүрэг ямар ямар эрх мэдлүүд нь хадгалагдаж үлдсэн бэ?

Зарим өргөн баригдсан хуулийн заалтуудаас одоо энэ ажлын хэсэг дээр зарим зүйлүүдийг өөрчилсөн юм шиг байгаа юм. Би одоо энэ Байнгын хороонд ч байхгүй, ажлын хэсэгт ч байхгүй учраас. Анхны хэлэлцүүлэг байгаа учраас асууж байгаа шүү. Өмнө нь юу гэж тайлбарлагдсан бэ? Энэ.

Хоёрдугаарт, нэг зүйл байна. Энэ хууль дээрээ ингээд ингэж болохгүй. Болохгүй юу байх вэ. Үүнийг ингэж шийдвэрлэнэ гээд заачихдаг. Гэхдээ биелүүлээгүй тохиолдолд бас яах вэ гэдэг талаар. Одоо манай ихэнх хуулиуд чинь тийм нэг. Зарим хүмүүс тийм тунхгийн чанартай гээд байгаа чинь энэ байна л даа. Процесс тал руу нь сайн ялгаж өгсөн үү. Энэ хуулийг. Гэдэг талаар. Ийм хоёр асуулт асууя. Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Би аль болохоор товч хариулаад, манай ажлын дэд хэсгийнхэн тайлбарласан нь дээр байх. Тийм ээ.

Эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах гэдэг бол яах вэ, ер нь энэ чинь үгийг нь задлаад ярих юм бол ойлгомжтой л доо. Тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засагтай холбоотой, нийгмийн асуудалтай холбоотой асуудал дээр энэ хуульд заасан тусгайлан олгосон чиг үүрэг гэж байгаа юм. Одоо жишээлбэл, өмчийн ашиглалт гэдэг юм уу, одоо хог хаягдлын менежмент гэдэг юм уу, гэрэлтүүлэгч гэдэг юм уу ингээд тодорхой чиг үүргүүд байж байна. Тэгэхээр энэ дээр шийдвэр гаргана.

Ер нь Үндсэн хуулийн нэр томьёо, хууль зүйн нэр томьёо л доо. Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1 дээр тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт гээд жишээлбэл заачихсан байж байгаа.

Тэгэхээр эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлаар яг тэр олгосон чиг үүргийн хүрээнд аймаг нь өөрөө бие даасан нийтийн эрх зүйн субъект гэдэг. Энэ утгаараа өөрөө асуудлаа бие даан шийдвэрлэнэ. Энэ утгаар тэр гарах шийдвэр нь энэ шийдвэр байх юм гэдэг ийм агуулга байгаа.

Манай ажлын дэд хэсгийнхэн нэмээд хэлчих. Тийм ээ.

**Л.Энх-Амгалан:** Хэн хариулах юм?

**Ж.Сүхбаатар:** Нэмж хэлэх юм байна уу?

**Л.Энх-Амгалан:** Ж.Ганбаатар гишүүн чинь тодорхой зүйл асуугаад байна шүү дээ. Тийм. Санал хэлээд л явна. Тийм.

Ж.Ганбаатар гишүүний асуугаад асуулт бол тэр эдийн засгийн асуудлаар бие дааж шийдвэр гаргана гэдэг нь нөгөө орон нутаг өөрөө концесс зарлах эрх байгаа юм уу. Тийм ээ. Бонд гаргах эрх байгаа юм уу. Зээл авч болох юм уу гэх мэтээр ингээд олон эдийн засгийн ийм асуудлууд байна гэж байна л даа.

Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Юу гэж асууж байгаа вэ гэхээр өөрөө бие дааж татварын хувь хэмжээнд өөрчлөлт оруулах боломжтой юу? Тийм ээ.

Одоо жишээлбэл дүүрэг боломжгүй байгаа шүү дээ. Нийслэл боломжтой харагдаж байгаа юм. Тэгэхээр дүүрэг боломжтой юу гэдэг. Жишээлбэл, одоо нийслэл сүүлд нь нэг юу гаргасан шүү дээ. Өргөн барьсан хуулиар дүүрэг боломжтой гэж байсан юм. Одоо ажлын хэсэг дээр энэ чинь засагдсан юм уу, үгүй юу гэдэг талаар.

Хоёрдугаарт, бонд гаргана гэдгийг юу гэж ойлгож байгаа вэ? Яг одоо бид юу гэж ойлгох юм бэ? Дүүрэг гаргаж болох уу? Нийслэл гаргаж болох уу? Аймаг, сум гаргаж болох уу?

Энэ дүүргийн төсөв чинь тэгээд голлоод гол гурван зүйлээс бүрдэж байгаа шүү дээ. Тийм ээ. Хүн амын орлогын албан татвар, газар. Нөгөөдөх нь юу билээ. Үл хөдлөхийн хөрөнгийн албан татвар. Энэ дээрээ нэмээд өөрөө одоо ингээд боломжтой зүйлүүд дээр татвараа одоо оногдуулаад явах тэр эрх мэдэл нь байгаа юм уу?

**Л.Энх-Амгалан:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Сая аймгийн л асуудал ярьж байна л даа. Тэгэхээр яах вэ дүүрэг гээд явчхаж байна. Дүүрэг нь бол яг тусдаа ингээд яригдах юм.

Ер нь Ж.Ганбаатар гишүүний хэлдгийг байж болох хэмжээнд нь бид тусгасан. Тэр үнэт цаас гаргах асуудал дээр бид иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь зөвшөөрөл олгоно гэж заасан байгаа.

Ер нь өмчийн асуудал, орон нутгийн сангийн асуудал эд нарыг бид яг тодорхойлж өгсөн. Жишээлбэл, дүүрэг өмчтэй байх тухай асуудлыг хүртэл зааж өгсөн байж байгаа. Одоо байхгүй шүү дээ. Өмч гэж. Тэгэхэд энэ хуулиараа сумын өмч гэдгийг хүртэл зааж өгч байгаа.

Тэгэхээр яг саяны хэлж байгаа болгоныг шийдэх гэж хичээсэн. Яг энэ аймгийн заалтууд явж байгаа болохоор. Би зүгээр тухайн тухайн заалт дээрээ л ярьчихвал яадаг юм бол гэж бодоод байна. Дээр нь Д.Ганзориг багш нэмчихье.

**Л.Энх-Амгалан:** Ажлын хэсэг. 82 дугаар микрофон. Д.Ганзориг багш.

**Д.Ганзориг:** Баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч нэг зүйлийг тодруулж хэлсэн.

Тэгэхээр Үндсэн хуулийн 62.1 гэсэн энэ заалт байгаа юм. Бид нэгдүгээрт энэ хуулийн нэр томьёо, энэ ойлголтдоо нэгдүгээрт багтаж, түүндээ захирагдаж энэ нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийнхаа томьёоллыг хийх ёстой.

Мэдээж эдийн засгийн асуудал гээд яг тодорхой асуудлуудыг тоочооч ээ гэвэл их олон асуудлууд энд орно.

Сая Ж.Ганбаатар гишүүн тодруулж асууж байна. Тухайлбал, хоёр зүйл дээр. Энэ дээр юу байгаа вэ гэхээр татварын асуудал. Хоёр дахь нь, үнэт цаас, концессын асуудал гээд.

Тэгэхээр энэ дээр юу вэ гэхээр бие дааж шийдвэрлэх нэг асуудал байна. Мөн төв Засгийн газраас гаргасан шийдвэрийн хүрээнд, тэр хязгаарын хүрээнд шийдвэрлэх тэр нэг асуудал байгаад байгаа юм. Ялангуяа энэ дээр татвар тогтоох бол хуулиар тогтоосон хүрээ хязгаарын хүрээнд.

Хоёр дахь нь өмчийн удирдлагаа хэрэгжүүлэх асуудал манай Үндсэн хуулийн саяын нэмэлт, өөрчлөлтөөр мөн орсон. Энэ дээр хязгаартай шүү гэж.

Гуравдугаар нь, юу вэ гэхээр үнэт цаас, концесстой холбоотой асуудал дээр энэ 15.1.6 дээр бас энэ асуудал орсон байгаа. Энэ дээр юу вэ гэхээр аймаг, нийслэлийн иргэдийн Хурал энэ асуудлыг шийдвэрлэнэ гэж.

Тэгэхээр энэ 15.1.6-гаар энэ бол дүүрэг дээр байхгүй гэж ингэж ойлгогдоод ингээд явах байгаа юм.

Хоёрдугаарт, юу вэ гэхээр ер нь манай энэ хуулийн 3.3 гэсэн нэг ийм заалт байгаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүрэг, бүрэн эрхийг бусад хуулиар тодорхойлохдоо энэ хуульд заасан зарчим, нийтлэг зохицуулалтыг баримтална гэж байгаа.

Саяны энэ дурдаж байгаа асуудлууд бол дандаа салбар хуулиудаар шийдэгдээд явах асуудал. Жишээ нь түрүүн Х.Нямбаатар сайдын асуудалд гарч байсан өмчийн асуудал яах юм бэ гэж. Энэ бол орон нутгийн өмчийн хууль гээд тусгайлсан хуулиараа хийнэ. Гэхдээ юунд захирагдах вэ гэхээр энэ хуулийнхаа.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдээр тусгайлан гэсэн үг нийслэлийн эрх зүйн байдлыг хуулиар тусгайлан тогтооно гээд ингээд Үндсэн хууль шиг нэлээн хэд орсон байгаа юм л даа. Тусгайлан гээд.

Тэгээд Үндсэн хуулиа ишилж байгаа заалт нь бол 62.1. Яах вэ. Тэр бол шийдвэрлэхийн хамт, нийгэм, эдийн засгийн асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт хүн амыг татан оролцуулж болно гэсэн нэг ийм агуулга байгаа.

Хамгийн гол ишлэх ёстой зүйл нь энэ тусгайлан гэж заахгүйгээр энэ хуулиуд дээрээ. Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн гэж байгаа юм.

Энэ бол Б.Чимид гуай “корпораци байна” гэсэн үгийг “корпораци” гэдэг бол тэр бонд гаргах, нийгэм, эдийн засгийн субъект байх, корпораци байх гэсэн агуулгатай юмаа гэж сүүлд нь тайлбарласан. Энэ хүрээнд тэр аймаг, нийслэл, сум, дүүргийн нийгэм, эдийн засгийн эрх хэмжээ тодорхойлогдох ёстой.

Тийм учраас энэ дээр тусгайлан гэж заахгүйгээр 58.1 гэж заагаад, 58 дугаар зүйлийн 1-ийн хүрээнд 62.1. Үндсэн хуулийн 62.1. 59 дүгээр зүйлийн 2 байгаа юм. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно гэсэн.

Энэ Үндсэн хуулийн энэ 3 агуулга заалтдаа нийцүүлж их тодорхой болгохгүй бол манай энэ органик хуулиуд дээр тэгээд тусгайлан тогтооно, Үндсэн хуулиар тусгайлан тогтооно гэдэг. Тэгтэл дараа нь ахиад органик хууль дээр тусгайлан тогтооно гэдэг.

Тэгээд сүүлдээ процессын хууль дээрээ хаягдчихдаг. Тэгээд ер нь тодорхойгүй. Аймаг, орон нутгийн эрх мэдэл ингээд тодорхойгүй хаягдчихдаг юм байгаа учраас яг энэ Үндсэн хуулийн 58.1, 59.2, Үндсэн хуулийн 62.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** 1 минут нэмж болох юм байна шүү дээ. Г.Занданшатар даргад 1 минут нэмж өгье.

**Г.Занданшатар:** Ингэвэл яг энэ зах зээлийн харилцааныхаа үед энэ аймаг, сум, дүүргийн бие даасан байдал, нийгэм, эдийн засаг. Тэгээд цаашдаа энэ сумууд томрох. Эдийн засгийн агуулгаараа хөгжих.

Ер нь хот ч гэсэн энэ корпораци байх гэдэг агуулга бол дэлхийн бүх улсын хот, орон нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын зарчимд байгаа юм.

Тэгэхээр хуучин нутгийн удирдлагын тогтолцоо, шинэ удирдлагын тогтолцоо хоёрын дунд, зах зээлийн тогтолцоо хоёрын дунд гацчихаад байгаа энэ юмыг түгжээг тайлахын тулд энэ заалтуудыг нь тодруулж өгөх нь зүйтэй байх.

Эцэст нь ганцхан зүйл хэлэхэд Л.Энх-Амгалан дарга бид хоёр өчигдөр бүх аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шинээр сонгогдсон дарга нартай цахим хурал хийж санал бодлыг нь сонссон. Дахиж үүнийг зохион байгуулна гэж хэлсэн.

Хурлын дарга нар маш идэвхтэй оролцъё. Санал бодлоо хэлье. Үүнийг дахиж зохион байгуулаач ээ гэж хүсэлт тавьсан. Тэрийг мэйлээр болон LawMaker, LawParliament-ээр дахин авч бас нэг анхаарах нь зүйтэй байх.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга үг хэллээ. С.Амарсайхан гишүүн.

Одоо тэгвэл санал хураалт. Санал хураалт. Гишүүд ээ.

13 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Ж.Батсуурь гишүүний санал хураалтын машин ажиллахгүй байна гэж байна шүү. Тэрийг анхаараарай.

Энэ санал дэмжигдлээ.

Одоо 7 дугаар зүйлээр санал хураалт хийнэ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол байгаа юм байна.

Үүнээс өмнө түрүүний 6 дугаар зүйл дээр Г.Занданшатар даргын хэлж анхааруулсан болон бусад гишүүдийн хэлсэн саналуудыг дахиж хоёрдугаар хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэгт өгч байна.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёолол 7.

4.Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“7 дугаар зүйл.Сум**

7.1.Сум нь хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн

биелэлтийг хангах, иргэдэд үзүүлэх хуульд заасан үйлчилгээг зохион байгуулах үндсэн нэгж мөн.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

13 гишүүн оролцож, 10 гишүүн зөвшөөрч, 76.9 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

**Г.Занданшатар:** Одоо 5 дугаар санал хураалт, 8 дугаар зүйл дээр. Түрүүн 4 дүгээр санал хураалт, 7 дугаар зүйл дээр.

**Л.Энх-Амгалан:** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 8 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол байгаа юм байна.

Төслийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“9 дүгээр зүйл.Нийслэл**

9.1.Нийслэл нь төрийн дээд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, дүүргүүдийн үйл ажиллагааг зохицуулах, иргэдэд хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх нэгж мөн.

9.2.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлыг хуулиар тусгайлан тогтооно.”

Санал гаргасан ажлын хэсэг.

С.Амарсайхан гишүүн байна. С.Амарсайхан гишүүнээр тасаллаа. С.Амарсайхан гишүүн.

**С.Амарсайхан:** Түрүүн тодруулъя гэсэн хэд хэдэн асуудлыг бас дахиж тодруулахгүй бол болохгүй нь.

Энэ аймаг, нийслэл, сум, дүүрэг эдийн засгийн асуудлаа бие дааж шийдвэрлэнэ гээд заачхаад байгаа юм. Гэтэл энэ хуулийн төслийн 21, 24 дүгээр зүйл дээр заасан зарим асуудлуудтай нийцэхгүй байна.

Тухайлбал, аймаг, орон нутаг эдийн засаг, нийгмийн асуудлаа шийдвэрлэхдээ хамгийн гол асуудал нь өөрөө газар, газар зохион

байгуулалт, хот төлөвлөлт, тухайн орон нутгийн хотжилт, суурьшлын асуудал байдаг. Гэтэл энэ асуудлууд дээр 21, 24 дээр ерөөсөө нийслэлийн чиг үүрэг, аймаг, сум, дүүрэг дээр газар зохион байгуулалтын асуудлыг бүгдийг нь аваад хаячихсан байна. Газаргүйгээр энэ хот, тосгоны асуудлуудыг шийдвэрлэх ямар ч боломж байхгүй. Газар зохион байгуулалт.

Өмнөх хурал дээр бид ярьж байсан. Би санал гаргаж байсан. Одоо ингээд үндсэндээ хотын хөгжлийн асуудлыг шийдвэрлэнэ, сумын хөгжлийн асуудлыг шийдвэрлэнэ л гээд байдаг. Газар зохион байгуулалтын асуудал орхигдсон байгаа учраас энэ дээр ер нь ямар зохицуулалтаар яаж явна гэж харж байгаа юм бэ? Үүнийг нэгдүгээрт тайлбар өгөөч.

Хоёрдугаарт, энэ газрыг чинь цаашаа хэн нь хариуцах юм. Одоо энэ дээр ингээд эзэнгүй болоод орхигдож байгаа байхгүй юу. Улаанбаатар хот нийслэл нь дүүргийнхээ газрын асуудлыг шийдвэрлэх юм уу? Аймаг нь сумынхыг шийдвэрлэх юм уу? Хэн нь алиныхаа асуудлыг шийдвэрлэх юм гэдэг эзэн биегүй. Дээрээс нь ямар ч харьяалалгүй асуудал энд ороод ирсэн байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа нэгжийн тухай хууль дээр сум, дүүрэг, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын асуудлыг тухайн орон нутаг өөрсдөө шийдвэрлэнэ гээд ингээд заачихсан байгаа. Энэ орхигдсон байна уу? Эсвэл энэ дээр байхгүй байгаад байна уу? Бидэнд өгсөн материал дээрээ. Өмнө нь бид бас санал хураалгахад ярьж байсан асуудал шүү дээ.

**Л.Энх-Амгалан:** С.Амарсайхан гишүүн ээ. Энэ 24 дүгээр зүйл Нийслэлийн чиг үүрэг гээд.

Одоо ингээд гишүүд асуух асуултуудаа, тодруулах зүйлүүдээ, хэлэх үгээ ингээд зүйл зүйл дээр нь холбогдуулаад яриад явмаар байна.

Тэгэхээр сая таны асуусан асуулт бол хойно байгаа юм байна. Яг ингээд тусгайлсан асуулт, санал хураалт байгаа юм байна С.Амарсайхан гишүүн ээ. Энэ дээр ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн нэмээд тодруулга өгчих үү.

Зүйл зүйл дээрээ асуугаад яриад явбал яасан юм. Тэгэх үү.

Сая санал хэллээ. Тэгээд 24 дүгээр зүйл дээр дахиж ярьж гэсэн ийм санал хэлж байгаа юм байна.

Одоо санал хураалт.

12 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 66.7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 10 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

10 дугаар зүйл дээр санал байхгүй юм байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 12 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 13 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Энэ дээр санал байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа юм байна.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Нэгжийг өөрчлөх асуудлыг санаачлахдаа өмнө нь иргэдэд үзүүлж байсан үйлчилгээг дордуулахгүй байх зарчмыг баримтална.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд ээ.

12 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 58.3 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

С.Бямбацогт гишүүн зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасан юм байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 14 дүгээр зүйлийн нэрийн “зааг” гэсний дараа “нэгжийн нэр” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт. Санал хураалт. Гишүүд ээ.

Энэ санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

1-ийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:



14.3.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэрийг төрийн албан ёсны хэлээр нэрлэж, хаягийг монгол хэл бичгээр хаяглана.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт.

Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** С.Бямбацогт гишүүний асуудлыг ажлын хэсэг өмнө нь Д.Цогтбаатар гишүүн яриад, түрүүн сая санал хураалгахдаа ч бас уялдаж байгаа.

Тэгээд Д.Цогтбаатар гишүүн саналаа ирүүлээд, тэр саналыг нь их олон талаас яриад монгол хэл төрийн албан ёсны хэл, оноосон нэр гэж байгаад бид ерөнхийд нь зохицуулалт хийсэн байхгүй юу.

Тэгэхээр саяны заалтыг ажлын хэсэг ярилцсан. Гэхдээ яг энэ заалтаар нь энд оруулахыг дэмжсэн юм уу, тийм санал хураасан зүйл байхгүй. Гэхдээ ингээд яг хийчхэж бас болохгүй байгаад байгаа юм.

Бидний ажлын хэсгийн хуралдаан дээр ярьж байсан асуудлууд дотор бас яригдсан юмнууд бий. Наадах чинь бас хамаагүй ингээд юу яачхаж болохгүй байгаад байна л даа.

**Л.Энх-Амгалан:** Санал хураалт.

12 гишүүн оролцож, 3 гишүүн зөвшөөрч, энэ санал дэмжигдсэнгүй.

Ажлын хэсгийн биш, яг гишүүнийхээ хувиар, Байнгын хорооны гишүүнийхээ хувиар гаргаж байгаа, санал хураалт хийж байгаа юм байна.

Ингээд 14 дүгээр зүйлээр санал хураалт хийсэн. Одоо 15 дугаар зүйлээр санал хураалт хийнэ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 15 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгийн санал байгаа юм байна.

11.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.5, 15.1.6 дахь заалт нэмэх:

“15.1.5.орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн нэгжийн хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавхыг харгалзан хөрөнгө хуваарилна;

15.1.6.хуульд заасан үндэслэл, журмын дагуу концесс болон үнэт цаас гаргах асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Үг хэлнэ. Ж.Ганбаатар гишүүн үг хэлнэ. Ж.Батсуурь гишүүн.

Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Энэ дээр дүүрэг гэж яагаад нэмж болохгүй байна гэдгийг. Дүүрэг чинь одоо уг нь энэ аймгаас чинь хэд дахин том. Баянгол дүүрэг гэхэд л 240 мянган хүнтэй байна шүү дээ. Зарим аймаг 40 мянган хүнтэй байгаа биз дээ.

Тэгээд бид Үндсэн хууль ярьж байхад хамаагүй өөр байдалтай яриад боломжийг нь олгосон байгаа шүү дээ. Хот болох боломжтой байгаа шүү дээ. Гэтэл чинь одоо дүүргийн асуудлыг яагаад ингээд орхигдуулдаг юм бол.

Хот чинь ер нь ингээд зөвхөн Улаанбаатар хотод эрх нь өгөгдөхөөр дүүргүүд чинь хөгжихгүй байна шүү дээ. Улаанбаатар хот ер нь бусад аймгуудаас сул хөгжиж байгаа шүү дээ. Зарим аймгуудаас. Төсөв мөнгө сайн очдог аймгуудаас маш сул хөгжиж байгаа. Х, О, Ө үсэгтэй аймгуудаас маш дутуу хөгжиж байгаа шүү дээ.

Тэгэхээр бид энэ дүүргийнхээ асуудалд анхаармаар байна шүү дээ дарга нараа. Тэгэхээр би энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргая гэж бодож байгаа юм. “Дүүрэг” гэдэг үг нэмж өгөөч ээ. Би бичгээр гаргаж өгье.

Тэгээд яах билээ тэгэхээр. Дараа нь хураалгах уу? “Дүүрэг” гэдэг үг нэмж өгөөч ээ.

**Г.Занданшатар:** Одоо л өгнө шүү дээ.

**Ж.Ганбаатар:** Та нарын ярьж байгаа энэ гишүүдийн гаргасан санал гээд унагах байдалтай. Үүнийгээ болиорой. Дарга нараа. Гишүүний бүрэн эрхэд тэгж халдахгүй шүү. Дарга нараа.

**Л.Энх-Амгалан:** Ж.Ганбаатар гишүүнд зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хуудас өгчих.

Ж.Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Ажлын хэсэг дээр энэ хуулийн талаар нэлээд чамбай ярилцаж бүр үг үсэг, өгүүлбэр, агуулга бүрээр ярилцаж байгаа л даа. Гэхдээ энэ санал өмнөх хууль байсан уу гэвэл байсан юм. Энэ иргэдийн Хурал концесс, үнэт цаас гаргах асуудлуудыг.

Тэгэхдээ үүнийг өмнө нь би туршиж үзсэн хүн нь би өөрөө байгаа юм л даа. 2012 онд. Тийм. Тэгээд яасан бэ гэхээр Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо үүнээсээ илүү том эрхтэй байдаг. Бүх тооцооллыг хийгээд, хөрөнгө оруулагчаа олоод, хийх ажлаа шийдээд, график төлөвлөгөөгөө босгочхоод ингээд яг ажил руугаа орох гэнгүүт Сангийн яам зөвшөөрдөггүй. Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хоорондоо шийдээд байдаг.

Тэгээд хуулийн гаргалгааг нэгэнт л эрх өгч байгаа бол Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд хамааралгүйгээр бүрэн эрхийг нь өгөхгүй

бол энэ бол зүгээр ёс төдий юм болоод явдаг юм. Яагаад вэ гэхээр энэ зовлонг нь туулсан хүн нь би яг өөрөө байж байгаа байхгүй юу.

Бүх боломж нь байдаг. Хөрөнгө нь байдаг. Хөрөнгийн барьцаа нь байдаг. Эдийн засгийн үр өгөөж, тооцоо нь байж байдаг. Ингээд үүнийг цааш нь явуулахгүйгээр асуудлуудыг шийддэг.

Тэгэхээр үүнийг нэгэнт. Энэ чинь орон нутгийн өөрөө удирдах ёсны хамгийн л том эрхүүдийн нэг шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ ингээд хуульчлагдаад эрх юм шиг мөртлөө, их том эрх юм шиг мөртлөө Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хоёр дээр тэдний зүгээр гарын үзүүрээр л нуга дарагддаг.

Тэгэхээр үүнийг хуулийн гаргалгааг нь энд хамааралгүйгээр хийж өгөхгүй бол. Өмнө нь ийм эрх бас байсан уу. Байсан. Тэр эрхийг хэрэгжүүлэх гэж үзэж байсан уу. Үзэж байсан. Ингээд хийгдэж чадаагүй. Тийм болохоор үүнийг бас энэ хуульд маш тодорхой болгож оруулах өгөх боломж нь юу байдаг юм болоо гэсэн. Энэ байгаа. Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Ингээд цөмөөрөө дэгээр явъя. Тэгээд энэ ажлын хэсэгт. Ж.Батсуурь гишүүн ээ. Ажлын хэсэгт орсон гишүүд ингээд ажлын хэсгийнхээ саналаас өөр санал хэлээд байх юм. Тийм. Дахиад тодруулна гээд. Уг нь ажлын хэсэгт орсон гишүүд нь яг ингээд ажлын хэсгийн санал өгсөн нэг л ийм санал хураалт явмаар байна л даа.

Д.Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Энэ 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.6 хоёр маш том заалт байгаа юм. Ялангуяа 15.1.6.

2008-2012 онд энэ эрх байсан юм. Биш ээ. 2012-2016 онд энэ эрх байсан юм. Тэгэхдээ нутаг дэвсгэрийн нэгжийн хууль дээр байгаагүй юм. Нөгөө өөрийнх нь хууль дээр байсан юм. Төсвийн хууль, бусад хууль дээр байсан юм.

Тэгээд 2016 онд энэ заалтыг байхгүй болгосон юм. Байхгүй болгосны гол шалтгаан нь юу байна вэ гэхээр аймгууд концесс гаргасан юм билээ. Тийм.

Гол нь энэ хуульд заасан үндэслэл, журам гэдэг үг байхгүй л бол болохгүй байгаа юм. Монгол Улс бол нэгдсэн улс. Нэгдсэн төсөвтэй улс. Тэр хийгдэж байгаа концесс, хийгдэж байгаа юу бол заавал улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болж явдаг. Тэр агуулгаараа энэ заалт бол заавал байж байх ёстой юм. Тэгэхгүй бол орон нутгийн хийсэн концессыг улсын төсөв төлдөг. Өнгөрсөн 4 жил ч зөндөө төлсөн тохиолдол гарсан юм. Тийм. Тийм учраас энэ заалт орсон юм.

Дүүргийн тухайд дүүрэг концесс гаргана гээд эхлэхээр тэгээд задраад задраад яваад өгөх байх даа. Байдал хүндрээд л явна даа. Дүүрэг концесс гаргаад л, дүүрэг юу гаргаад эхэлбэл. Нийслэл дээрээ бүгд төвлөрөөд л явбал яасан юм бэ. Нийслэл нь тэртээ тэргүй дүүрэгтээ

хуваагдаад л явж байгаа юм чинь концесс, бондын бодлогоо мэдээж дүүрэг рүүгээ л хийнэ шүү дээ. Өөр хаашаа хийх вэ.

Тийм учраас нийслэл дээр төвлөрүүлж явбал яасан юм бэ гэсэн миний ийм л санал байдаг юм.

**Л.Энх-Амгалан:** Д.Тогтохсүрэн гишүүн санал хэллээ. Одоо санал хураалт хийнэ.

Түрүүний уншсан саналын томъёоллоор санал хураалт. Б.Пүрэвдорж гишүүн ээ. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 58.3 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

15.1.6-д “дүүрэг” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 4 гишүүн зөвшөөрч энэ санал дэмжигдсэнгүй.

**Г.Занданшатар:** Дэгийн 39.2-оор асуулт асууж. Нэгдүгээр хэлэлцүүлэг дээр, анхны хэлэлцүүлэг дээр асуулт асууж, хариулт авах дэг шинээр орсон юм билээ шүү. Ж.Ганбаатар гишүүн асуулт асууж болох байхгүй юу.

**Л.Энх-Амгалан:** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 16 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 17 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 18 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа юм байна.

Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“18 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч**

18.1.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь өмчтэй байна.

18.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга тус тус хэрэгжүүлнэ.

18.3.Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах эрхтэй.

18.4.Орон нутгийн өмчийн харилцааг тусгайлан хуулиар зохицуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгээс асуулт байна.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 39.11-д гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэж заасан.

Үндсэн хуулийн 58.1 дүгээр зүйлд аймаг, нийслэл, сум, дүүрэг хуулиар тусгайлан чиг үүрэг олгосон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, нийгэм, эдийн засгийн цогцолбор мөн гэж заасан.

Үүнийг Б.Чимид гуай субъект юм. Гадаад үг оруулахгүй гээд би “цогцолбор” гээд нэрлэсэн юм гэж байсан. Энэ үг нь “корпораци” буюу “corporate body” гэсэн үгийг тэгж орчуулсан гэж.

Тэгэхээр аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн гэсэн өмчтэй, санхүүтэй, орлоготой, зарлагатай, бондтой. Ер нь эдийн засгийн бие даасан нэгж байна гэсэн ийм агуулгад нийцүүлж энэ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийг. Үүнийг тодруулж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тусгайлан чиг үүрэг олгож болно гэж энэ эрхийг нээж тодруулж өгсөн.

Тэгэхээр энэ агуулгатай нийцүүлээд энэ өмчтэй байх. Ер нь эдийн засгийн харилцаанд бие даасан эрхтэй оролцох, дүүргүүдийн эрхийн асуудал байна. Аймгийн эрхийн асуудал байна. Тэгэхгүй бол бүгд ингээд улсын төсөв гэдэг нэг саванд бүх юмыг төвлөрүүлээд тушаачихдаг.

Тэгээд дээрээсээ улсын төсвөөс мөнгө гуйж тийм асуудал шийдэж өгөөч гэж амьдардаг ийм социализмын үеийн тогтолцоо засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээр ч гэсэн үүнтэйгээ уялдаад улсын төсөв дээр ч ингээд яваад байгаа юм л даа. Аймаг, сум бүгд өөрийн гэсэн орлого, зарлага байхгүй. Тэгээд тэрийгээ хөгжүүлэх сэтгэлгээ байхгүй.

Тэгээд дээрээс юм хуваарилахыг л. Сургууль барьж өгөөч, эмнэлэг барьж өгөөч. Тийм юм барьж өгөөч. Үйлдвэр барьж өгөөч гээд ингээд сууж

байдаг. Энэ хуучин үеийн тогтолцооны системийг л энэ нэгжийн хууль, нийслэлийн хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиуд дээр өөрчлөх шаардлагатай байна. Үүний үндсийг нь тусгаж өгөх хэрэгтэй байгаа юм л даа.

Тийм учраас би түрүүн тусгайлсан чиг үүрэг дээр 58.1-ийг заагаад байгаа юм. Тэгээд энэ дээр ажлын хэсэг ер нь ямар зарчим баримталсан юм бэ? Энэ гишүүд ч гэсэн яг тэр асуудлыг л голлож яриад асуугаад байна.

**Л.Энх-Амгалан:** Ж.Сүхбаатар гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

**Ж.Сүхбаатар:** Ж.Ганбаатар гишүүн, Г.Занданшатар даргын хэлээд байгаа асуудлаар яг энэ 18 дугаар зүйл шууд уялдаж байгаа.

Сум, дүүрэг анх удаа өмчтэй байна гэж орж ирж байгаа. Эхлээд өмчтэй байж тэр биеэ даасан байдлыг шийдэх асуудал ер нь цаашдаа урган гарах ёстой болдог. Өмч, татвар, төсөв гээд гурван юм байж байгаа шүү дээ. Гол суурь.

Тэгэхээр энэ дээрээ таны хэлж байгаа Үндсэн хуульд оруулсан тэр өөрчлөлтийн хүрээний 18.2-ын заалт байж байгаа. Яг тодорхой өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн хурал өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ.

Орон нутагт өмчийн хуулийн этгээд байгуулах эрхтэй гэж байгаа юм. Түрүүн Ж.Ганбаатар гишүүний хэлээд байгаа шиг дүүрэг орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах эрхтэй гээд одоо ч гэсэн явж байгаа. Гэхдээ үүнийг ингээд явахаар энэ орон нутгийн өмчит хуулийн этгээд хүчирхэгжээд, мөнгөжөөд, санхүүжилт нь, үйл ажиллагаа нь сайжраад ирэхээр зэрэг тэр тухайн дүүрэг үйл ажиллагаагаа олон бизнесийн харилцаанд оролцох болж байгаа шүү дээ. Компанийн тухай хуульд зааснаар үнэт цаасны харилцаа эд нарт оролцох гарцууд бий л дээ. Иргэний эрх зүйн харилцааныхаа хүрээнд цаашаа явчхаар.

Тэгэхээр яг аймаг гэдэг бол нэг ойлголт. Түрүүн Г.Занданшатар даргын хэлдэг нийтийн эрх зүйн субъект. Аймаг гэдэг бол яг тэр Үндсэн хуулийн 58.1-д зааснаар энэ бол засаг захиргаа, нутаг дэвсгэр. Тэгээд тодорхой чиг үүрэг, эдийн засаг, нийгмийн цогцолбор гэсэн ийм нэгж байгаа. Үүний гол субъект нь үйл ажиллагааг нь авч явдаг нь Хурал. Тэгээд гүйцэтгэх удирдлага болсон Засаг дарга байж байгаа.

Тэгэхээр яг энэ 18 дугаар зүйлд энэ асуудлууд ингээд орж өгсөн. Орон нутгийн өмчийн харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна гээд байгаа нь Үндсэн хуульд бол тусгай хуулиар зохицуулна гээд заадаг чинь тэр хууль нь. Одоо жишээлбэл Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хууль бол органик хууль байгаад байгаа юм. Тэгээд дахиад үүнээс өмчийн тухай хууль, тэр Улаанбаатар хотын тухай хууль гэдэг нь дахиад бүр тусдаа ийм хуулиуд болчихоод байгаа байхгүй юу. Салбар.

Тэгээд тэрийг нь тодотгож тусгайлсан гээд байгаа юм. Орон нутгийн өмчийн асуудал бол бүхэл бүтэн яг энэ хуулиар ганцхан шийдэгдэхгүй.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Энэ заалтуудыг дэмжиж байгаа. Энэ юмнууд ингээд анх удаа ингээд нэгжийн хуульд ороод явж байгааг дэмжиж байна.

Тэгэхдээ энэ дээр 18.3 дээр жишээ нь эрхтэй. Тэгээд үүнийгээ дагаад бас үүрэг, хариуцлага нь байна шүү гэдэг юмыг чухам эндээ оруулж өгөх үү? Зүгээр 18.4-дөө тусгайлсан хуулиар зохицуулахдаа оруулах уу? Тэр үедээ одоо үүнийгээ бид бас нэг ойлголцоод авах хэрэгтэй.

Би түрүүн бүлгийн даргын хэлсэн үг дотор тэр нэг анхаарах зүйл байгаа. Бид бүх хуулийг гаргахдаа ялангуяа энэ эдийн засагтай холбоотой биеэ дааж шийдвэр гаргадаг, дагаж хүлээдэг хариуцлага үүрэхтэй холбоотой юм ярихдаа энэ “Монгол Улс нэгдмэл” гэдэг үгийг бүх юмныхаа суурин дээр тавьж гаргаж байх ёстой байгаа юм. Ямар ч асуудал дээр.

Үүнийг тодруулахгүйгээр ер нь асуудлууд гарч эхэлсэн шүү дээ. Түрүүчээсээ. Уул уурхайн томоохон нөөцтэй, уурхайтай ийм аймгууд дээр хүртэл янз бүрийн яриа, оноо. Бид эндээ авч байгаа юмаа өөрсдөө л авна. Бусад газарт хамаагүй ч гэдгээс эхлээд юмнууд. Энэ чинь юмны эхлэл байхгүй юу.

Тэгэхээр тэр нэгдмэл улс гэдгийг заавал бид бүх юмныхаа суурь болгож бодож энэ шийдвэрүүдээ гаргаж байх ёстой гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, сая миний тэр асуусан асуулт. Эрхийнх нь хажуугаар үүрэг, хариуцлага юм нь байх юм бол болж байгаа юм. Ганцхан эрхтэй гээд заачхаар эрхтэй шүү дээ гээд л. Аймаг юм хийхдээ сүүлд нь мөнгийг нь гаргуулах болохоор улсаас нэхээд байдаг байж болохгүй.

Биеэ дааж шийдвэр гаргана гэдэг чинь үүнийхээ цаадах хариуцлагыг өөрөө л хүлээнэ гэсэн үг шүү дээ. Эрх нь байгаад үүрэг нь, хариуцлага нь байдаггүй юмыг хүлээн зөвшөөрөхөд их хэцүү.

Тэгэхээр харин зүгээр дараагийн хэлэлцүүлгээрээ юм уу, хуулийн этгээд байгуулах эрхтэй гээд үүнийг томъёолохдоо яах вэ бодно биз. Үүнийг дагасан хариуцлага, үүрэг нь бас тэндээ байх ёстой гэдэг нэг санааг.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Д.Тогтохсүрэн гишүүн. Хууль санаачлагч.

**Д.Тогтохсүрэн:** Би зүгээр найруулгын шинжтэй л хоёр санал хэлье.

18.2 дээр “тус тус” гэдэг үгийг хасчихмаар байгаа юм. “Иргэдийн хурлаас олгосон эрхийг хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ.” гээд тавьчихъя. “Тус тус” гэж хэрэггүй.

18.3-ыг “аймаг, сум, нийслэл, дүүрэг нь орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно.” гээд тавьчихмаар байна. Тэр хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор гэдэг бол хуульд байх үг биш. Илтгэлд байж болох л байх.

18.4-ийг “тусгайлан” гэдэг үгийг хасаад л “орон нутгийн өмчийн харилцаа хуулиар зохицуулна.” гээд л тавьчихвал яасан юм гэдэг ийм 3 зүйлийг би хэлье. Үүнийг дараагийн редакцийн үед анхаараад явчихвал яасан юм бэ гэж санал хэлж байгаа юм.

**Л.Энх-Амгалан:** Түрүүн Нямаагийн Энхболд гишүүний асуусан тэр нөгөө үүрэг. Үүрэгжүүлж байгаа үүргүүд юу байна вэ. Эрхийг нь өгч болно. Үүрэг нь юу байна вэ гэдэг дээр ажлын хэсгийн ахлагч үүрэг, хариуцлагын зохицуулалтууд юу байна вэ гэж. Тийм ээ.

Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Н.Энхболд гишүүн ч өөрөө хэлж байна.

18.4-ийн орон нутгийн өмчийн харилцаа бол яг тэр эрх үүрэг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдэг чинь тусгай хуулиараа зохицуулагдана шүү дээ.

Ер нь ийм зарчим байгаа. Энэ нэгжийн хууль бол юмыг хязгаарлах гэж байгаа хууль бас биш. Олон талаар. Ялангуяа таны хэлээд байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн асуудал дээр гээд ингэж байхад.

Үүнийг нь аль болохоор төсөв хөрөнгө, эдийн засгийн хувьд ер нь юмыг нь нээж өгөөд. Тэр хязгаарлах, үүрэг хүлээлгэх юмнууд нь тэр бусад хуулиараа гох дэгээнүүд нь тухай тухайн үедээ тавигдаж болдог байх ёстой байх.

Тэр орон нутгийн өмчит хуулийн этгээдийг яагаад тэр чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор гэж байгаа юм бэ гэхээр одоо чинь бас янз янзын орон нутгийн өмчит хуулийн этгээд, компаниуд чинь замаа алдаад байна. Хэрэгтэй хэрэггүй юм байгуулчихаад байна.

Гэтэл орон нутгийн яг өөрт нь олгогдсон чиг үүргийн юмыг хийхгүй бол энэ чинь орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно гэхээр бүр харин хашлагагүй болчихоод байгаа юм. Гол нөхцөл нь тийм байгаа байхгүй юу. Чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор.

Тэгэхээр яах вэ түрүүний Д.Тогтохсүрэн гишүүний хэлээд байгаа тэр хууль санаачлагчийн санааг тус тус гэдгийг нь авч хаяад орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах эрхтэй биш байгуулж болно гэдгээр ингээд заагаад.

Ер нь Н.Энхболд гишүүний хэлээд байгаа чинь төрийн болон орон нутгийн өмчийн засаглалын менежментийг сайжруулах бүр багц том хуулийг манай Улсын Их Хурал реформ хийе гээд байгаа шүү дээ. Ирэх жил гэхэд үндсэндээ.



Тэгэхээр энэ хуулиараа л тэр асуудлууд нь явахгүй бол. Манай нэгжийн хууль дээр одоо нэг ийм заалт хийчхээд л араас нь тэгээд нэг тэгнэ гэсэн юм л ингээд хийгээд байхаар бас хууль зүйн техникийн хувьд шаардлага байна уу, үгүй юу гэдэг байна л даа. Тэгэхдээ санааг нь би ойлгож хүлээж авч байна.

**Л.Энх-Амгалан:** Саяын гишүүдийн хэлсэн саналуудыг бас дараагийн хэлэлцүүлэгт оруулахад бас анхаараарай. Ажлын хэсгийнхэн.

Санал хураалт.

13 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 69.2 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 19 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 20 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Энэ дээр Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна.

Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“20 дугаар зүйл. Орон нутгийн чиг үүрэг**

20.1.Орон нутгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

- 20.1.1.орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт;
- 20.1.2.орон нутгийн өмчийн удирдлага;
- 20.1.3.орон нутгийн төсөв, татвар, төлбөр, хураамж;
- 20.1.4.орон нутгийн сан;
- 20.1.5.орон нутгийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр;
- 20.1.6.орон нутгийн үйлдвэрлэл, хүнс, хөдөө аж ахуй;
- 20.1.7.хүн амын унд, ахуйн хэрэгцээний ус хангамж;
- 20.1.8.худалдаа, үйлчилгээний зохицуулалт;
- 20.1.9. орон сууц, нийтийн аж ахуй;
- 20.1.10.орон нутаг дахь нийтийн тээвэр;
- 20.1.11.суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоол;
- 20.1.12.гудамж, талбайн нэр, хаягжилт;
- 20.1.13.хөшөө дурсгалын зохицуулалт;
- 20.1.14.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламж;
- 20.1.15.орон нутгийн аялал жуулчлалын бодлого, менежмент;
- 20.1.16.хог хаягдлын менежмент;
- 20.1.17.оршуулгын газрын зохицуулалт;

20.1.18.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

20.1.19.гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу;

20.1.20.орон нутгийн цэвэрлэх байгууламж;

20.1.21.орон нутгийн зам, гүүр;

20.1.22.суурин газрын гэрэлтүүлэг;

20.1.23.бэлчээрийн ашиглалт, хамгаалалт.

20.2.Хуулиар зохих нэмэлт оруулсны үндсэн дээр орон нутгийн чиг үүргийг нэмэгдүүлж болно.

20.3.Нутгийн өөрөө удирдах байгууллага энэ зүйлийн 20.1-д заасан чиг үүргээс гадна Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан нутаг дэвсгэрийнхээ тодорхой асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Энэ орон нутгийн чиг үүрэг гэдэгт энэ газар зохион байгуулалт, түүний хэрэгжилт гэдэг зүйл нь орхигдсон байна гээд түрүүн С.Амарсайхан гишүүн хэлсэн.

Энэ чинь өөрөө хууль дундаа хийдэл гараад. Одоо аймгийн Засаг дарга нар хүртэл газар зохион байгуулалтынхаа асуудлыг шийдэх боломжгүй болно шүү.

Тийм учраас “газар зохион байгуулалт, түүний хэрэгжилт” гэсэн зүйлийг нэмэх ийм саналтай байна.

Ажлын хэсгийнхэн энэ тал дээр одоо энэ чинь орхигдсон юм байна гэж. Үүнийгээ нэмж оруулахгүй бол болохгүй гэдгийг хэлье.

Тийм учраас зарчмын зөрүүтэй санал хураалгаж өгөхийг хуралдаан даргалагчаас хүсэж байна. Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Ажлын дэд хэсэг. 82 дугаар микрофон. Д.Ганзориг багш.

**Д.Ганзориг:** Орон нутгийн чиг үүрэг гэдгийг бид ямар утгаар тодорхойлсон бэ гэхээр энэ хуулийн 4.1.4 дээр. Уучлаарай. 4.1.5 дээр байна. Уучлаарай. 4.1.6 дээр.

Нутгийн өөрөө удирдах байгууллага хариуцан шийдвэрлэх эдийн засаг, нийгмийн асуудал гэсэн нэг ийм.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ хууль батлагдаад, мөрдөгдсөнөөс хойш энэ заасан асуудлууд ажил хэргийг нутгийн өөрөө удирдах байгууллага 100 хувь хариуцаад явна гэсэн нэг ийм зарчим.

Харин газрын хувьд Үндсэн хуульд байгаа “газар, түүний хэвлий, байгалийн баялаг төрийн өмч” гэж. Өөрөөр хэлэх юм бол газрыг бас төрөөс салгаж болохгүй. Өөрөөр хэлэх юм бол газар өмчлөгчийн хувьд төрийн өөрийнх нь зайлшгүй хийх бас тодорхой функцүүд бол байна.

Тэгэхээр энэ утгаар нь юу вэ гэхээр үүнийг 100 хувь орон нутагт өгч болохгүй юм байна. Тийм учраас төрийн нэрийн өмнөөс орон нутгийн байгууллагуудаар хэрэгжүүлж болох буюу төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүрэг гэдгийн 27.5.17 дээр энэ заалт өөрөө орчихсон байгаа. Газрын харилцаа, газар зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт гэж.

Гэхдээ үүнийг орон нутгийн байгууллага хэрэгжүүлэхдээ төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэж байгаа гэдэг утгаараа хэрэгжүүлээд ингээд явах юм гэж ажлын хэсэг дээр ярьсан байгаа юм.

**Г.Занданшатар:** Асуулт.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр чиг үүргийн шинжилгээг Швейцарын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн.

Тэгээд манай энэ хуулиуд дээр чиг үүргийн давхардал, хийдэл маш их байдаг. Зөвхөн Байгаль орчны яаман дээр тэр үед хоёр гурван жилийн өмнө намайг Хэрэг эрхлэх газарт ажиллаж байхад энэ хуулиудын шинжилгээг программаар хийж үзэхээр 98 ийм давхардал гарч байсан. Хуулиуд дээр.

Ингээд Барилга, хот байгуулалтын яам гээд ингээд яамдаар явж байсан байх. Явж байсан байгаа. Тэгээд Байгаль орчны яаман дээр гэхэд л одоо тэр байгаль орчныг хамгаалах асуудал, сумын Засаг дарга дээр, аймгийн Засаг дарга дээр, Байгаль орчны яаман дээр ингээд хэд хэдэн газар давхардаад. Энэ нь нөгөө үйлчлүүлэгч дээр ч чирэгдэлтэй, хариуцаж байгаа хүмүүстээ ч гэсэн ингээд дунд нь хаягддаг, хийдэгддэг нэг ийм баахан давхардал, хийдэл.

Тэгээд яг энэ орон нутгийн чиг үүрэг. Энэ Хэрэг эрхлэх газраас хэн оролцож байна. П.Зоригтбаатар дарга энд хариулах ёстой. Энэ чиг үүргийн шинжилгээн дээр тулгуурлаж үүнийг гаргасан уу? Үүнийгээ уялдуулсан уу?

Сүүлд нь яг ингээд заачхаар бас орон нутгийн эрх мэдэл нэг талаасаа хязгаарлагдсан юм шиг. Чиг үүрэг нь. Хуулиар олгосон бусад ч гэдэг юм уу зааж өгөхгүй бол энэ дээр бас ахиад нэг хийдэл, давхардал, зөрчил гарах вий. Зарим нь ингээд яам, Тамгын газар хариуцдаг энэ тэр гээд л янз янзын асуудлууд гардаг. Сая газрын асуудал гэхэд л Хан-Уул дүүрэг дээр Байгаль орчны яамтай давхардал гараад л ирэх жишээтэй.

Тэгэхээр газрын асуудал, байгаль орчныг хамгаалах, газрыг хамгаалах асуудал нь орон нутагт байх жишээтэй. Үүнийг ингэж их нарийн салгаж авахгүй бол ерөнхий ингэж явах бас их аюултай юм билээ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, 5 жилийн төлөвлөгөө энэ тэр гээд бас тусдаа заачихсан. Тэр хойно, урд ч гэсэн харагдаж байна лээ. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуультай уялдуулахгүй бол аймгийн дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт чинь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн яамтай холбогдож дээрээсээ нэгдсэн журмаар удирдана энэ тэр гээд.

Тэгээд энэ бүхнийг ингэж нэлээн сайн заахгүй бол бас хэт хязгаарлах энэ тэр маань зөрчил гаргах уу, үгүй юу гэдэг дээр. Хэрэг эрхлэх газраас яг энэ хамааралтай хууль дээр П.Зоригтбаатар дарга яагаад оролцохгүй байна.

Энэ хурал дээр тэгээд П.Зоригтбаатар дарга энэ асуудалд бас хариулах хэрэгтэй. Энэ чиг үүргийн шинжилгээ дууссан уу? Дууссан бол үүнтэй уялдуулсан уу? Үүнийг судалсан уу? Ажлын хэсгийнхэн. Энэ маш том судалгааны ажил хийгдсэн. Олон экспертүүд оролцсон.

**Л.Энх-Амгалан:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Түрүүн Ж.Ганбаатар гишүүн яриад байна.

Бас онол, арга зүйтэй гэдгийг л ойлгомоор байна. Орон нутгийн чиг үүрэг гээд энэ дээр байхгүй болчихлоо биш. Тэр 27 дугаар зүйл дээр санал хураах юм нь дээр байгаад байгаа юм.

Ер нь бусад улсын хууль дээр ч гэсэн тэр орон нутаг бол өөрөө дангаараа хүлээх чиг үүрэг, хуваалцах чиг үүрэг гэж бас байдаг. Засгийн газартайгаа хамтрах гэдэг юм уу. Төрийнхөө дээд байгууллагатай.

Тэгэхээр газрын асуудал бол 27 дугаар зүйлийн 5.17 дээр ингээд бэлэн байж байгаа байхгүй юу. Энэ нь гэрээгээр бидний тэр хойно гарах тэр ойлголтуудтайгаа холбоотой байгаа. Түүнээс саяны хэсэг дээр ороогүй болчихлоо гээд байхгүй болж байгаа хэрэг биш.

Хоёр дахь юм. Г.Занданшатар даргын тэр хэлээд байгаа. П.Зоригтбаатартай байнга л уулзаж байгаа л даа. П.Зоригтбаатар дарга надад шинжилгээний тухай үзсэн. Тэр шинжилгээ бүрэн дүүрэн болоогүй юм билээ. Яг одоо би бүрэн дүүрэн аваад ашиглачихъя гэсэн. Өөрөө нэгтгэж аваад яваад. Энэ шинжилгээ иж бүрэн гарч дүгнэлтээ бүрэн гаргачхаагүй юм билээ.

Тэгээд их зовлонтой. Ер нь чиг үүргийн асуудал бол та ч гэсэн төрийн ажлыг хийж байгаа хүн. Ойлгож байгаа. Ажил үүргийн хуваарь шүү дээ энэ чинь. Ажил үүргээ хуваарилах асуудлыг дагалдуулаад төсөв, хөрөнгийн хуваарилах асуудлууд дараа нь үүсэж байгаа юм.

Тэгэхээр ажил, үүргийг хуваарилахад янз бүрийн маргаан, зөрчил, давхардал гардаг л даа. Зүгээр энэ дээр бол бид таны тэр хэлээд байгаа тэр шинжилгээний дүн, материалуудыг өөр өөрсдөө ажлын дэд хэсгийн гишүүд, ажлын хэсгийн гишүүд үзсэн, харсан. Анх удаа Монголд ингэж хийж байгаа.

Бид чиг үүргийг хуваарилахгүй байж дандаа эрх мэдэл хуваарилалт яриад байдаг. Хийх ажлаа хуваарилж байж ингээд араас нь эрх мэдлээ хуваарилах ёстой.

Тэгэхээр энэ анхны оролдлого болж байгаа. Мэдээж засаж сайжруулах юмнууд гарна. Гэхдээ энэ яг одоо тэр хойд талын заалтуудаа харах юм бол ерөнхий юмнуудаасаа тодорхой юмнууд руу шилжсэн юмнууд байгаа шүү. Саяны заалт хийчхээр л дуусчхаж байгаа юм бол байхгүй.

Тэгээд манай ажлын дэд хэсэг нэмчихье.

**Л.Энх-Амгалан:** 82 дугаар микрофон. Д.Ганзориг багш.

**Д.Ганзориг:** Г.Занданшатар даргын асуултад гурван зүйлийг үндэслэж хариулъя.

Нэгдүгээрт, бид бол ер нь энэ хуулийн 6, 7 дугаар зүйлийг харах юм бол аймаг, сум, багийг ингээд гурвууланг нь харах юм бол хийх ажлууд буюу функцүүд нь нэгдүгээрт хоорондоо давхцахгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл аймаг нэг өөр үүрэгтэй, сум нэг өөр үүрэгтэй, баг нэг өөр үүрэгтэй гэж.

Үүгээрээ түрүүн давтан яригдсан 58 дугаар зүйлийн тусгайлан олгосон чиг үүрэг гэдэг энэ зүйлийг тайлбарлая. 6, 7, 8 дугаар зүйлүүд өөрөө нэгдүгээрт зорьж байгаа юм. Энэ үүднээсээ юу гэхээр энэ 20 дугаар зүйлээр нийтлэг орон нутгийн чиг үүргүүдийг тогтоогоод.

Харин дараа нь 21, 22, 23 дугаар зүйлүүд дээр тодорхой түвшинд ямар ямар чиг үүргүүд байх юм бэ гэдгийгээ задалж байгаа. Энэ чиг үүргүүд дээр өөр хоорондоо давхацсан зүйл байхгүй.

Хоёрдугаарт нь, одоогийн хүчин төгөлдөр байгаа хууль нэг их тийм том согогтой байсан. Тэр юу вэ гэхээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын юм уу, эсвэл Хурлын нийтлэг бүрэн эрх гэдэг тэр нийтлэгүүдийг заасан нэг тийм зохицуулалттай байсан юм.

Тэгэхээр бид энэ нийтлэг гэдэг. Ялангуяа аймаг, сум хоёр тус тусдаа шүү гэдэг ийм ойлголтоор хийж байгаа.

Гуравдугаарт, энэ түрүүн дурдсан. 3 дугаар зүйлийн 3 дахь заалтаараа тодорхой чиг үүрэг, тодорхой бүрэн эрхийг олгохдоо, салбарын хуулиар олгохдоо энэ хуульд заасан зарчим нийтлэг зүйлүүдийг баримтална гэдэг ийм. Өөрөөр хэлэх юм бол салбар хуулиуддаа одоо энэ аймгийн тухай ямар чиг үүрэг байна, сумын чиг үүрэг байна. Үүнийгээ харж байгаад одоо хэн дээр нь ямар бүрэн эрх олгох вэ гэдэг асуудлыг тухай бүр шийдэх ийм арга зүйгээр хийсэн ийм зүйл байгаа юм.

**Г.Занданшатар:** Тодруулъя. 39.11-ээр 2 минут тодруулах юм байна. Л.Энх-Амгалан дарга аа.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Энэ ажлын хэсгийн хувьд энэ их том дэвшилттэй. Нөгөө чиг үүрэг хуваарилах. Тийм учраас чиг үүргийн шинжилгээ гэж энэ Нэгдсэн Үндэстний Байгууллага, Швейцарын хөгжлийн агентлаг дээр хоёр, гурван жилийн өмнөөс энэ чухал төслийг хэрэгжүүлж байгаа юм л даа.

Манай төрийн байгууллагуудын хоорондох чиг үүргийн давхцал, хийдлээс болоод хүнд суртал, чирэгдэл. Нөгөө талдаа ажлын саад бэрхшээл ч их гардаг.

Энэ нь ингэж хуваарилж байгаа нь их сайн. Гэхдээ энэ маань нөгөө Үндсэн хуулийн 58.1-д заасан аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тогтоосон тусгайлсан чиг үүрэг бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, нийгэм, эдийн засгийн цогцолбор мөн гэхээр яг үүндээ Үндсэн хуулийн 58.1-ээр хязгаарлагдах болчихоод байгаа юм.

Тэгээд 59.2-ыг энд оруулж өгвөл их сайн байна. 59.2-т тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн онцлогоос шалтгаалж хуулиар тусгайлсан чиг үүрэг нэмж өгч болно гэсэн агуулга байгаа. Нэмж өгч болно гэсэн. Аймаг аймаг. Зарим Дархан, Эрдэнэт ч байдаг юм уу зарим бүс нутагт онцгой нөхцөл байдал үүсэхийг ингэж нээж өгөхгүй бол энэ маань яг үүгээрээ ингээд хязгаарлачих юм бол бас их.

Ер нь энэ чиг үүрэг хуваарилах бол их том дэвшил боловч бас их болгоомжтой хандахгүй бол үр дагавар нь дараа нь бусад хуулиудаар юутай байж магадгүй. Тэгэхээр тэр хуулиудыг ишлээд, Үндсэн хуулийн тэр заалтуудаа ишлээд ингээд тодруулаад явах нь зүйтэй байх.

Тэр чиг үүргийн шинжилгээ дуусаад тодорхой болбол их чухал юм байгаа юм даа. Бусад хуулиуд ч гэсэн дагаад маш олон хуульд өөрчлөлт орох ёстой. Одоо байгаль орчныг хамгаалах гэхэд л сумын, аймгийн, багийн бүх дарга давхацсан учраас түүний нөлөөллийн үнэлгээ авах гэж маш том асуудлууд болж байдаг. Яг амьдрал дээр маш олон асуудлууд. Энэ газрын асуудлууд байна. Энэ асуудлуудыг зохицуулах, нэр мөр шийдэхэд энэ бас их чухал ач холбогдолтой болно.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга аа. Тэр нөгөө төрийн байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ нөгөө П.Зоригтбаатар дарга Хэрэг эрхлэх дээрээс хийгдээд их сайн ажил хийгдэж байгаа.

Тэгээд Төрийн албаны зөвлөлтэй бид яриад ер нь Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ дээр нэг хэлэлцүүлэг хийе гэж төлөвлөж байгаа. Тэгээд таны өгсөн чиглэлийн дагуу бас хэлэлцүүлгийг хийгээд. Одоо ингээд энэ хуулийн хэлэлцүүлгүүдийн үе бас энэ зарчмаа бариад явах нь зөв юм байна гэж бодож байна.

Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Би нэг асуулт асуугаад, үг хэлье гэж бодож байсан. Ж.Ганбаатар гишүүн хойно заалтууд нь байгаа болохоор саналаа татлаа гэхээр больчихож байгаа.

Хэрэв бүр түрүүн С.Амарсайхан дарга ч яриад л байсан. Сая Ж.Ганбаатар гишүүн яриад байна. Энэ юмнуудаа тухай тухайн аймгийнх, сумынх гэсэн юм нь дээр заавал оруулна гээд байгаа юм бол зүгээр одоо жишээ нь аймгийнх гэж ярихад 21.1 гээд дууссаныхаа оронд 21.2 гээд дахиад нэг товчхон заалт, зүйл нэмээд тэгээд төрөөс нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх бусад чиг үүрэг гээд нэг уут тавьчихсан байвал яасан юм бол доо л гэж санал болгох гэж байсан юм.

Тэгээд нэгэнт татаад авчхаад тэгээд ард талынхаа заалтуудаар зохицуулагдаад явна гэж байгаа бол одоо тэрийг орхичихъё. Заавал нэгэнт ард нь ойлгомжтой бичсэн юмыг энд оруулах шаардлага байхгүй л юм байгаа юм.

Г.Занданшатар даргын хэлсний хувьд сая наад юмнуудыг, хамгийн сүүлд хэлсэн юмнуудыг чинь дөнгөж сая бид тэр 20.2, 20.3 дээр хуулиар зохих нэмэлт, өөрчлөлт оруулсны үндсэн дээр орон нутгийн чиг үүргийг нэмэгдүүлж болно гээд орсон байгаа шүү дээ.

Зүгээр энэ дээрээ заавал Үндсэн хуулийнхаа зүйл, заалтыг нэмэх үү, тавьж өгөх үү, үгүй юу л гэдэг асуудал байна гэж надад бол тэгж санагдаад байх юм.

**Л.Энх-Амгалан:** Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Би уг нь Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөхөөр энэ зарчмын зөрүүтэй саналын томьёоллоо өгчхөөч ээ гээд хоёр гурван хоног хэлүүлсэн юм л даа. Тэгээд өгөөгүй байхгүй юу.

Уг нь авсан бол үүнийг чинь судална шүү дээ. Тийм ээ. Тэгээд ард байгаа, урд байгаа тэгээд ингээд. Одоо тэгээд өгөхгүй байгаа юм чинь бид яах юм бэ. Би чинь одоо зөндөө ажлын хэсэг ахалж байгаа шүү дээ. Тэгээд л энэ чинь гишүүдэд тараагаад өгчихдөг юм шүү дээ уг нь. Байнгын хорооныхоо гишүүдэд.

Энэ дээр тэгээд анхаарна биз дээ. Энэ чинь тэгээд та өөрөө мэдэж байдаг. Бусад нь одоо орж ирээд үүнтэй чинь танилцаж байна шүү дээ. Санал хэллээ. Баярлалаа.

**Л.Энх-Амгалан:** Гишүүд санал хэллээ.

20 дугаар зүйлээр. Саяын зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт хийнэ.

Санал хураалт. Гишүүд ээ. С.Амарсайхан гишүүн ээ. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 58.3 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Одоо 21. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 22 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 23 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 24 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийн 25 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Ж.Ганбаатар гишүүн. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншъя.

Хуулийн 25 дугаар зүйл. Дүүргийн чиг үүрэгт нэмэх заалт.

25.1.10.дүүргийн ерөнхий төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг нэмж, 21.15-д хот, суурингийн газрын авто зогсоолын байршил, арчилгаа гэж нэмэх гэж байна.

Саналаа тайлбарлах уу? Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Тэр дугаар нь болохоор би яагаад тэр дугаар тавьсан бэ гэхээр энэ яг өргөн баригдсан хуульдаа байсан дугаарыг нь тавьсан юм.

Тэгээд ажлын хэсэг дээр энэ дүүргийн чиг үүрэг гэдгээс олон чиг үүргүүдийг хассан юм билээ. Яг өргөн баригдсан хуулиас нь олон чиг үүргийг нь хасчихсан.

Тэгээд би зүгээр зарим чиг үүргүүдийг нь хассан нь зөв байх гэж харсан юм. Тэгээд энэ хоёр чиг үүргийг үлдээгээч ээ гэдэг л санал тавьж байгаа юм. Энэ өргөн баригдсан хуульд нь байсан. Тэр ерөнхий төлөвлөгөө, мөн одоо тэр авто зогсоолын асуудлыг үлдээгээч ээ гэж ажлын хэсэгт санал тавьж байгаа юм.

Би үүнийг бодож олоод гаргасан юм биш. Өргөн баригдсан. Тэр мэргэжлийн хүмүүс нь өргөн барьсныг ажлын хэсэг хассан юм билээ. Тийм



учраас Байнгын хорооны гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье. Дүүргийн чиг үүрэг дээр ярьж байгаа шүү. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Л.Энх-Амгалан дарга аа.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Яах вэ. Энэ нөгөө санаа зовж их яриад байгаа асуудлууд нь болохоор үүнийг дагаад их том реформ, өөрчлөлтүүд хийгдэхгүй бол төсвийн болон их олон өөрчлөлт орох шаардлагатай болж байгаа юм л даа.

Тухайлбал, орон нутгийн чиг үүрэгт Д.Тогтохсүрэн дарга аа. Жишээлбэл, сургууль, цэцэрлэг, соёлын төв, орон нутгийн бүх байгууллагуудын засвар, ашиглалт, үйлчилгээ. Ашиглалт гэхээр дулаан, халуунаас авхуулаад бүх зүйл орон нутгийн чиг үүрэгт хамаарч байгаа юм.

Тэгэхээр сургууль, эмнэлгийн засвар, үйлчилгээ энэ тэр бол улсын төсвөөс биш орон нутгийн төсвөө санхүүжиж хийгдэхээс өөр аргагүй байдалд орно. Чиг үүрэг нь яг тэгж хуваарилагдаад ирэхээр. 20 дээр тэгээд ороод явчхаж байгаа юм.

Авто зогсоолын үйлчилгээ гээд сая дүүрэгт нь болохоор авто зогсоолын үйлчилгээг нь дүүрэг хариуцаад, авто зогсоолоо болохоор хот нь хариуцаад явж байгаа. Ингэж салгахаар ийм зөрчлүүд үүсээд байгаа учраас л үүнийг их сайн харах ёстой юм шүү гэдэг гол санааг хэлээд байгаа юм л даа.

Тийм учраас Ж.Ганбаатар даргын саналыг ч гэсэн дэмжиж байна. Тэгээд чиг үүрэг бол өөрөө цаанаа төсвийн болон санхүү, эдийн засгийн үр дагаврууд их учраас үүнийг бусад хуультай уялдуулах талдаа их сайн тооцох шаардлагатай болно.

Одоо нийслэл гэхэд бүх сургууль, цэцэрлэг, эмнэлгийнхээ засвар, үйлчилгээ, ашиглалтыг хариуцах болоод л ирэх юм бол энэ төсвийн шал ондоо хуваарилалт болоод явчихдаг юм.

**Л.Энх-Амгалан:** Ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Энэ хэлж байгаа санаануудыг ойлгож байна.

Дүүрэг болохоор зэрэг жаахан өөр юм билээ. Бид чинь дүүрэгт баахан юм задлаад тавьчихсан байсан юм. Дараа нь нийслэлийнхэнтэй ярьсан. Дараа нь дотроо ярьсан.

Аймагтай үүнийг харьцуулаад байхгүй. Энэ чинь нэг амьтай юм байна л даа. Хот юм байна л даа. Бид яах вэ дүүрэг гээд ингэсэн.

Тэгээд Улаанбаатар гээд нэг цэвэрлэх байгууламжтай, нэг усан хангамжтай, нэг цахилгааны хангамжтай нэгдсэн нэг дэд бүтцийн байгууламжтай байгаад байдаг.

Тэгэхээр тэр бүтцийн зохион байгуулалт чинь газар зохион байгуулалт, төлөвлөлт эд нар чинь яг тийм хотын нэгдсэн юм нь дотор яваад байгаа байхгүй юу.

Тэгээд дүүрэг гэдэг нь яах вэ ингээд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнхээ юугаар бид ингээд хийчихсэн. Тэгээд яг одоогийн дүүргийн зохион байгуулалтаар яг салгаад юмыг нь ингээд өгчихье гэдэг байдлаар ингээд өгчхөөр тэр хотын нэгдсэн юм нь өөрөө бас байхгүй болчихоод байгаа байхгүй юу. Ер нь бол зүгээр шулуухан хэлэхэд.

Тэр дүүргийн энэ чиг үүрэг дотор тэр “хэрэгжилт” гэдэг үг бол байхгүй л дээ. Өмнө нь яах вэ оруулаад явчхаж. Энэ бол хурал Засаг даргын бүрэн эрх дотор янз бүрийн санаанууд орно шүү дээ. Энэ дээр юу орж байна вэ гэхээр дүүргийн хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт гээд орчхож байгаа юм. Үндсэн чиглэл. Дүүргийн чиг үүрэг шүү дээ. Түүнээс биш яг дүүргийн Засаг даргын албан тушаалтны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлоогүй. Энэ бол нийтийн эрх зүйн субъектийн чиг үүрэг.

Манайхан хэд хэдэн удаа ярихдаа нэг зүйлүүдийг юу яагаад байна. Энэ бол тэр нэгжийнх нь чиг үүргийн асуудлыг яриад байгаа юм. Үүнээс чинь тусдаа дахиад ард нь хурлын Засаг даргын бүрэн эрхүүд дахиад тусдаа тэр газрын байна уу, бусад байна уу хуулиудаараа дахиад тэр бүрэн эрхүүд нь хурал Засаг даргын бүрэн эрхээр задраад задраад тодорхой бүрэн эрхүүд нь тусгагдаад явчхаж байгаа байхгүй юу. Энд л тусгагдчихгүй бол болохгүй дээ биш.

Тэгэхээр энэ Ж.Ганбаатар гишүүний хэлээд байгаа асуудлууд эндээ орчхоод байгаа. Зүгээр тэр нийслэл дээр нэлээн юмыг нь тодруулаад өгчихсөн гэдэг нь бол тэр агуулгатай нь. Нийслэлийнхэнтэй маш их удаан суусан. Би эсрэг ч байсан. Тэгээд ярилцаад байсан чинь сүүлдээ яалт ч үгүй.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Санал хураалт. Саяын Ж.Ганбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт хийе. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 6 гишүүн зөвшөөрч, 50.0 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

Тэгвэл саяын саналыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт хийе. Санал хураалт.

Ер нь энэ зохицуулалт орсон л юм байна. Илүү тодорхой болгоё л гэж байгаа юм байна шүү дээ. Тийм ээ.

12 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрсөн учраас түрүүний санал хураалтыг хүчингүй болголоо.

Одоо түрүүний уншсан Ж.Ганбаатар гишүүний зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт хийе.

Энэ чинь зүйл зүйлээрээ хураачхаж байгаа байхгүй юу. Ж.Ганбаатар гишүүн ээ. Зүйл зүйл дээрээ учраас. Тэгэхээр нөгөө зүйл зүйлээрээ хурааж байгаа учраас тухайн зүйл дээр нь санал хураалт хийхгүй бол хүндрэл үүсэж байна.

12 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 58.3 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 26 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 27 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 28 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 29 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 30 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 31 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 32 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 33 дугаар зүйл дээр ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол байна. Үүнийг уншъя.

Төслийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.6.Нутаг дэвсгэрийн иргэдийн болон хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд 3 өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт 5 өрх тутмаас, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хэсэг тус бүрийн 20 өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг хуралдаан болохоос ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө тухайн баг, хорооны оршин суугчдад мэдээлэх бөгөөд хуралдах байршил, цагийг тусгасан байна.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Хуралдааны товыг. Тийм ээ. Г.Занданшатар дарга, Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа.

Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Энэ дээр механикаар 3 өрх тутмаас 400-аас дээш өрхтэй багт 5 өрх тутмаас гээд тэгэхээр бас жаахан ойлгомжгүй нөхцөл байдал үүсэж магадгүй.

Энэ талаар Д.Тогтохсүрэн дарга, Ж.Сүхбаатар дарга нар бид ч гэсэн олон удаа ярьж байсан. 2023 оны нутгийн захиргааны түр дүрэмд 10 гэрийн даргаас дээш Улсын Их Хурал хүртэл хурлуудыг дэс дараалан байгуулж, элдэв хэрэг явдлыг шүүмжлэн хэлэлцэж, олонхийн саналаар таслан шийдвэрлэж байвал зохино гэсэн ийм ардчилсан дүрмийг анх

зохиогоод. Тэгээд 1960 оны Үндсэн хууль хүртэл энэ 10 гэрийн дарга гэдэг юм аймагт үйлчилж байсан.

Энэ 10-тын систем бол ер нь Хүннүгийн үеэс Монголын нүүдэлчдийн удирдлагын, засаглалын маш оновчтой хэлбэр байж ирсэн юм билээ.

Тэгээд 10 гэрийн даргаа юуны дарга нар бол их аятайхан сонгочихно шүү дээ. Хөдөөгийнхөн бол хамгийн тулхтай. Тэгээд тэр 4 шаардлага нь ард олны зовлон зүдгүүрийг мэдэх, олны тусыг бодох, ховдог шунахай, авлигач бус, харгис ноёдод нүүрчлэхгүй, бичиг үсэгт боловсронгуй байх гэсэн шаардлагуудыг тавьсан. 1923 оны Ардын засгийн түр дүрэм, Нутгийн захиргааны түр дүрэмд тэгж заагаад. Тэгээд 10 гэрийн даргыг сонгоод. 10 гэрийн дарга нар нь сумын хурлаа бүрдүүлээд. Сумын даргаа сонгоод. Сумаасаа аймгийг сонгоод. Хазгар Гэндэн гэдэг Ерөнхий сайд 1924 оны Үндсэн хуулийн анхдугаар Улсын Их Хуралд тэгж сонгогдож ирсэн байдаг.

Энэ засаглалын уламжлалаа ч гэсэн бодоод энэ 10 гэрийн дарга нарыг төлөөлж 10 гэр нь хуралдаад нэг даргаа төлөөллөө сонгож явуулаад ийм байдлаар хийвэл илүү уламжлалаа шинэчлэлийг ч хангасан ийм зарчим болох юм биш үү гэсэн ийм горимын саналтай байна. Зарчмын саналтай байна.

**Л.Энх-Амгалан:** Ж.Сүхбаатар гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

**Ж.Сүхбаатар:** Яг энэ асуудлын тухайд ярих юм бол энэ нөгөө багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд ирэх ирцийн босгын асуудал байгаад байгаа.

Тэгэхээр яг 10 гэр гээд явах юм бол цөөхөн 150 өрхтэй баг байлаа гэж бодоход чинь 15 хүн ирээд шийдчихнэ гэхээр иргэдийн Нийтийн Хурлын хуралдаан. Энэ бол доод босгыг нь тавьж байгаа.

Зүгээр ер нь 10 гэрийн зохион байгуулалттай баг дээр байх уу, байхгүй юу гэдэг асуудал бол бид өмнө нь нэлээн ярьсан. Ер нь орон нутгаас ч гэсэн ирсэн саналуудын ихэнх нь 10 гэрийг тийм 10-тын зохион байгуулалтыг дэмжсэн юм бол байхгүй л байсан л даа. Манай ажлын дэд хэсэг дээр ч яриад дэмжигдээгүй. Бүлэг дээр яригдсан. Улсын Их Хурлын олонхийн бүлэг дээр яригдсан. Дэмжигдээгүй.

Тэгээд энэ асуудал ороогүй. Зүгээр яг энэ дээр бид өнөөдрийнхөө амьдралын, манай ажлын хэсэгт чинь Д.Ганболд, Ж.Батжаргал, Т.Энхтүвшин гээд аймгийн дарга нар байсан гишүүд маань орсон.

Тэгээд аймгуудынхаа, багуудынхаа нөхцөл байдал, өрхийн тоог хууль санаачлагч маань бас ярьсан. Ингээд л энэ тоог л гаргаж ирж байгаа. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд аль болох иргэдийн оролцоог оруулсан, төлөөллийг нь харгалзсан байх тоог л тогтоосон байгаад байгаа. Тэр утгаар л оруулсан юм. Энэ тоог 3, 5, 20 гэдэг өрхийн асуудлыг. Тутмаас гэдгийг нь 1-ээс доошгүй хүн ирэх. Хуралдааны кворум[[lat. quorum](#)] байгаа. Зүгээр энэ нь 3 нь их бага байна гэвэл нэг өөр байх.

Ер нь манай 400-гаас дээш өрхтэй баг дээр 5 өрх тутам гээд яагаад хийсэн гэхээр энэ бол үндсэндээ нэг аймгийн төвийн багуудын асуудал дээр ингэж бас ялгаатай хийе гэдэг байдлаар хийж өгсөн. Улаанбаатарт хороо нь 20 өрх тутам байя гэдгээр ингээд хийсэн.

Тэгээд энэ дээр маш их хэл ам гарч байгаа. Сая орон нутгийн сонгуулиар ч гэсэн ер нь энэ саяны заалттай холбоотой хуралдааныхаа газрыг хэлдэггүй, цагаа хэлдэггүй. Тэгээд энэ мэдээлдэггүй. Тэгээд оролцоо их муутай. Ирц нь юу болсон нь мэдэгдэхгүй. /минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Энэ ийм л юм байна л даа. 30 орчим хувь оролцоод л. Өрхүүдийн. Тэгээд шийдвэр гаргаад. 400 өрхтэй газар бол 20 орчим хувь нь өрхийн төлөөлөл ороод л шийдвэр гарахаар ийм л юм орж ирж байгаа юм байна.

Гэхдээ бас яг орон нутаг, хөдөө нутагт иргэдийн Хурал их түвэгтэй болдог юм. Тэгээд бодвол энэ ажлын хэсэгт орсон, орон нутагт ажиллаж байсан хүмүүс бас тал талынхаа юмыг бодолцож ийм тоо оруулж ирсэн байгаа болов уу гэж л бодож байна.

Нэг асуулт байна. 20 өрх тутмаас тус бүрээс нь 1-ээс доошгүй хүн заавал 1-ээс доошгүй гэж бичих ямар шаардлага байсан юм бол. Үүний утга нь юу байна. Өрх тутмаас 1 хүн гэвэл. Жишээ нь, тухайлбал нэг өрхөөс 10 хүн ирж болох нь байна шүү дээ.

Тэгээд цөөхөн өрх ирээд хоёр, гурван өрхөөс 10, 10-н хүн ирчихлээ гэж бодоход олон хүн байна гэж бодъё л доо. Тэгэхэд цөөхөн хэдэн өрхийн одоо ёстой нөгөө нэг хуйвалдаан зохион байгуулдаг маягаар хийе гэвэл аль олон хүнтэй өрхүүдэд зар хүргүүлээд л. Та нар 5 хүнтэй ирчхээрэй гээд явчхад тэр хавийнхаа асуудлыг шийдээд байх хэмжээний ийм боломжийг энэ 1-ээс доошгүй хүн гэж бичсэн чинь олгоод байгаа юм биш үү. 1 л хүн байхад болох биш үү.

Эсвэл иргэн нэг айлд 5 нь ч хүн бай, 2 ч хүн бай тэр багийн л иргэн учраас тэгээд л асуудал шийдэж байгаа нь тэрүүгээрээ явна гэж тооцсон уу? Иргэний оролцоог нь бодсон юм уу, өрхийн оролцоог нь бодсон юм уу гэдэг асуулт бас гарах гээд байна л даа.

Тэр яагаад тэр 1-ээс доошгүй гэдэг үг нь ингэж орсон юм?

**Л.Энх-Амгалан:** Ж.Сүхбаатар гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

**Ж.Сүхбаатар:** Яах вэ. Ер нь 1 гэж ингээд явж байсан юм. Тэгээд манай ажлын хэсэг дээр улсууд ярьж л байсан. Яагаад 1 гэж.

Тэгээд ер нь 20 өрх тутмаас 1 гээд хэлчхээр чинь тэр 20 өрх тутмыг төлөөлдөг нэг л тийм төлөөлөгч тусдаа бас дахиад нэг тийм хүн байх юм болов уу гэж жишээлбэл би бол тэгж бодсон.

Тэгэхээр 1-ээс доошгүй гэж. Энэ чинь хүн чинь энэ иргэдийн шууд оролцооны байгууллага шүү дээ. Иргэдийн нийтийн хурлын хуралдаан гээд бид нэрлээд байгаа юм. Яг үнэндээ энэ чинь хууль зүйн хувьд цуглаан байхгүй юу. Шууд ардчиллын хангаж байгаа. Зүй нь бол бүх л хүн цуглаад л юмаа шийдэж байх ёстой. Энэ бол зүгээр хуралдааны босго байгаад байгаа юм. 20 өрх тутмаас 1-ээс доошгүй хүн ирчихвэл л энэ хүчинтэйд тооцогдоно шүү гэж.

Таны хэлдгээр тэгээд тэндээсээ 20 өрх тутмаасаа их олон хүн ороод ирчихвэл гэж байна. Уг нь тэгвэл тэр нь шууд ардчиллын өргөн оролцоотой л байж байгаа хэрэг болно л доо. Нэг хүн гээд тавьчаар чинь 20 өрх тутмаас заавал нэг төлөөлөгчийг та нар дундаасаа сонго л гэсэнтэй адилхан л болох юм болов уу гэж ойлгогдоод байгаа юм. Буруу ойлгогдож байна уу. Би бол тэгж л ойлгоод байгаа юм.

Энэ чинь шууд ардчиллын байгууллага байж аль болохоор л бөөнөөрөө тэр хүмүүс нь оролцож л байвал цуглаан л юм чинь. Бид хуралдаан л гээд байгаа юм. Түүнээс тэр багийн бүх хүн чинь цуглаад ч уг нь хуралдаж болохоор л байх ёстой л доо. Иргэдийн Нийтийн Хурал чинь.

Иргэдийн Нийтийн Хурал чинь бол бие даасан тусдаа бусад байгууллагатай адилхан биш шүү дээ. Бүх иргэд нь шууд ардчиллын журмаар оролцдог. Зүгээр доод босгыг нь л хэлж байгаа юм. Хуралдаан хүчинтэйд тооцох. Тэр 20 өрхөөс олон хүн ороод ирвэл одоо тэр сонгуулийн насны хүний эрх нь л байж байгаа юм л даа.

**Г.Занданшатар:** Тодруулъя. Дарга.

**Л.Энх-Амгалан:** Дэд ажлын хэсэг. Ц.Товуусүрэн. 89 дүгээр микрофон.

**Ц.Товуусүрэн:** Энэ болгоомжлол зөв л дөө.

Тэгэхдээ энд хамгийн гол нь юу вэ гэхээр түрүүн бид баг хэсгийн зохион байгуулалттай байна гээд хийчихсэн. Нөгөө баг гэснийгээ тодорхойлсон хэсэгт.

Тэгэхээр энэ толгой дээр нэг ийм өгүүлбэр байгаа л даа. Нутаг дэвсгэрийн иргэдийн болон хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмаар гэдгээрээ бол нэг өрхөөс их олон хүн бүрдүүлээд хурлын ирцийг хангана гэсэн ойлголт байхгүй болно гэж ингэж ойлгох ёстой байгаа юм. Өөрөөр хэлбэл хэсэг тус бүрийн төлөөлөл бол заавал байж хурлын ирц бүрдэнэ шүү гэсэн санааг энд давхар тусаж байгаа юм. Үүнийг нэмж тайлбарлах гэсэн юм.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Энэ механикаар ингээд шууд тоо зааж байгаа нь яах вэ багийн нийтийн хурлын ирц бүрддэггүй, хүмүүс оролцдоггүй. Тэгээд тэр систем ажиллахгүй байгаагийн улмаас нэг ийм аргалж байна л гэсэн үг л дээ.

Яг үндсэндээ энэ системчилъе гэх юм бол 10 гэр хуралдаад. Хуучин бол 150 өрхөөс нэг сум бүрдэж байсан. Тэгээд 15 хүн хуралдаад сумын даргаа сонгоход илүү чанартай сонгодог байжээ гэж ярьдаг.

10 гэр дээр энэ бэлчээр, ус, нутгийн зохион байгуулалт. Тэгээд 10 гэрийн дарга дээр хамгийн тулхтай, түшигтэй, бичиг үсэгтэй бол бичиг үсэгтэй, боловсролтой бол боловсролтой.

10 гэрийн даргад заавал бичиг үсгийн боловсролын шаардлага хангахгүй байна гэж байгаа юм. Энэ уламжлалаараа бол энэ 10 гэрийн дарга нар хуралдаад. Тэгвэл нийтийн төлөөллийг хангаж чадна. 10 гэр хуралдаад ийм асуудлаар ийм байр суурь баримтална. Чамайг төлөөлж явууллаа гээд.

Зүгээр энэ дээр чинь 3 өрх тутмаас 1-ээс доошгүй хүн энэ тэр гээд хэсэг тус бүрийн 20 өрх тутмаас тус бүр 1-ээс доошгүй хүн гэхээр хэдэн ч хүн байж болох хэрэгтэй. Хэсэгчилж зааж байгаа юм шиг мөртлөө 1-ээс доошгүй хүн гэхээр чинь тэр 100 хүн ч байж болно гэсэн үг шүү дээ. 10 хүн ч байж болно. 1-ээс доошгүй гэдэг чинь дээшээгээ хязгааргүй гэсэн үг.

Тэгэхээр энэ маань өөрөө их зөрчил дагуулна. Ийм учраас 10 гэр нь хуралдаад асуудлаа яриад ийм хүнийг дэмжье, энэ асуудлаар ийм байр суурь илэрхийлье гээд 1 юм уу, 1-ээс доошгүй хүн. 1-ээс доошгүй гэх юм бол 10 гэрээс 2 хүн ч явж болно. 3 хүн ч явж болно гэж. 2-оос доошгүй хүн ч гэж болно. Хүний тоо нь 15 болоод цөөд нь гэж үзэж байгаа бол.

Ингэж системчилж өгөхгүй бол зүгээр механикаар 3 өрх тутмаас, 5 өрх тутмаас гэх юм бол энэ ажиллахгүй. Дахиад бөөн будилааны эх сурвалж болно. Тэгээд 1-ээс доошгүй хүн гэхээр 1 өрхөөс байна уу, нэг хэсэг өрхөөс нэг хэсгээс хэдэн ч хүн байж болно гэсэн санаа шүү дээ. Энэ бол ийм механик өөрчлөлт болох гээд байгаа учраас энэ бол дэмжиж боломгүй санал байна.

**Л.Энх-Амгалан:** Яах юм? Та зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргах юм уу?

Эхлээд ажлын хэсгийн саналаараа санал хураалт хийчих үү? Тэгье.

**Г.Занданшатар:** Тэгээд ажлын хэсгийн санал дуусчих. Тэгээд энэ чуулган энэ тэр дээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал энэ тэрийг авч яг амьдрал дээр ямар байна. Саналыг авч байгаад ер нь анхны хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах л чиглэл гарч таарах юм байна.

**Л.Энх-Амгалан:** Тэгвэл та чуулган дээр анхны хэлэлцүүлэг дээр яг энэ заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөх юм байна. Тийм үү.

Одоо ямар ч байсан ажлын хэсгийн.

**Г.Занданшатар:** Бүлэг дээр унагаж яригдаагүй л дээ.

**Л.Энх-Амгалан:** Бүлэг дэмжээгүй юм байна. Тийм. Ажлын хэсгийн санал хураалтаар. Ажлын хэсгийн саналаар санал хураалт хийе. Санал хураалт.

Уг нь 10 гэрийн зарчим сэргээвэл их зөв л юм билээ дээ.

12 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 58.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслийн 33 дугаар зүйлд 33.7 дахь хэсэг нэмэх.

“33.7.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн дараах иргэдийн Нийтийн Хурлын хуралдааныг сум, дүүргийн Засаг дарга шинээр томилогдсоны дараа зохион байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Цуцалчихлаа. Ж.Ганбаатар гишүүн.

**Ж.Ганбаатар:** Дээрх заалтуудыг ингээд харж байхад яах вэ яг ингээд ойлголтоороо бол ийм заалтуудыг зөрчвөл яах вэ гэдгийг бид бол ойлгочхож байгаа байхгүй юу. Энгийн ойлголттой хүмүүс бол бүгд ойлгож байгаа юм. Зөрчиж болохгүй. Шүүх шийдвэр гаргана гээд.

Амьдрал дээр яаж байгаа вэ гэхээр энэ хуулийн заалтын чинь ихэнх нь зарим нь зөрчихөж байгаа юм. Тэгээд шүүхээр явдаг процесс нь хоёр, гурван жил болоод бүх юм чинь гацчихаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр өөрөө энэ чинь хуулийг аягүй тийм сонин ойлгодог хэсэг бүлэг хүн байна шүү дээ. Одоо жишээлбэл дээр тэр хорооны хурлыг одоо энэ доод талын 33.7 ч гэсэн ялгаагүй.

Уг нь энэ хуулийг тэгж зөрчихгүй гэдэг процесс нь, тэр санкц нь гэх юм уу, юу гэх юм, үүрэг нь гэх юм уу. Маш тодорхой л байх ёстой. Би бас үүдэнд дэд ажлын хэсгийнхэн хэлсэн юм л даа.

Тэгээд би яадаг вэ гэдгийг дахиад хэлье. Зөрчихдөг. Хуулийг зөрчихдөг. Тэгээд тэр зөрчсөн гэдгээр нь шүүхэд өгчихдөг. Зөрчөөд болсон хурал чинь өөрөө бүрэн эрхээ хэрэгжүүлээд явчхаж байгаа байхгүй юу. Шүүхийн процесс чинь өөрөө хоёр, гурван жил хүлээгдэж байна шүү дээ.

Энэ нь өөрөө амьдрал юу хоёр чинь зөрөөд байгаа шүү гэдгийг бас сануулж хэлье. Үүнийг манай Баянгол дүүрэг ч гэсэн энэ дээр бас асуудлууд гарсан шүү дээ. Баянзүрх дүүрэг өмнөх жилүүдэд бас яав. Үүнийгээ бас хууль боловсруулсан хүмүүс, ажлын хэсгийнхэн анхаарна биз дээ.

Тэгээд нэг зүйл хэлэхэд надаас бусад нь бараг дийлэнх нь ажлын хэсгийнхэн юм шиг байна шүү дээ. Би бол өнөөдөр л авч байгаа шүү үүнийг. Нямаагийн Энхболд дарга бид хоёроос бусад нь.

Тэгээд энэ чинь тодруулах юмнууд зөндөө.../минут дуусав/



**Л.Энх-Амгалан:** Санал хураалт.

11 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 63.6 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 34 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 35 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 36 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 37 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 38 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 39 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 40 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа юм байна.

Төслийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.6.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гурвын нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.

*Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн мөрдөнө.”*

Санал гаргасан Ажлын хэсэг.

Нямаагийн Энхболд гишүүн, С.Амарсайхан гишүүнээр тасаллаа.

**Н.Энхболд:** Одоогийн хуульд чинь ийм зохицуулалт байгаа биз дээ. Гуравны нэг хүртэл нь.

Тэгээд үүнийг заавал 2024 оноос гэдэг нь ямар учиртай юм?

Тэгээд яагаад ийм санал гарч байгаа юм? Бид чинь сумын удирдлагын чадавхын асуудлыг баахан ярьж ярьж байгаад л тэгээд ерөөсөө. Би бол тэрийг улс төрийн шалтгаанаар ч гэж үздэггүй. Ерөөсөө сумын хурал, сумын удирдлагын асуудал, сумын байгууллагуудын удирдлагын асуудлын чадавх их суларч байна.

Тийм учраас яг суманд сонгогдож байгаа хүмүүс бас ч гэж тэндээ боловсролтой, мэдлэгтэй, ажлын туршлагатай. Хүмүүсийн итгэлийг тодорхой хэмжээгээр олж авсан тийм хүмүүс сонгогдож байна гэж үздэг шүү дээ.

Ерөөсөө энэ байхгүй болсноос хойш үнэхээр бас нэг хэсэг шүүмжлэл гарсан. Одоо орон нутгийн хуралд сонгогдож байгаа хүмүүсийн туршлага, мэдлэг боловсролын түвшин их доошоо орлоо. Шийдвэр гаргах чадавх нь

муудаж байна гээд баахан ярьж ярьж байгаад л гуравны нэгийг нь ядаж ажилд томилж төрийн захиргаанд ажиллуулж байя гэсэн ийм хууль гаргаад яваад мөрдөөд ирсэн шүү дээ. Би тэр бол нэг их тийм асуудал үүсгээгүй гэж бодож байгаа.

Гэсэн чинь одоо эргээд нөгөөхдөө юу яагаад. Дахиад хэдэн жилийн өмнө бид нэг туршиж үзээд болохгүй байна гэж үзээд өөрчилсөн юмаа буцаагаад энд оруулаад ирлээ шүү дээ. Эсвэл энэ хооронд тэр аймаг, сум, орон нутгийн хуралд нэр дэвшиж байгаа хүмүүсийн чадавх, мэдлэг, боловсрол хуучин шүүмжлэгдэж байсан хэмжээнээсээ илүү сайн болсон. Одоо бол заавал хурлын Төлөөлөгчид төрийн алба хаагаад.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Ажлын хэсгийн ахлагч. Ажлын дэд хэсгээс Д.Ганзориг багш. 82 дугаар микрофон.

**Д.Ганзориг:** Тэгэхээр ер нь нэг ийм л асуудал байгаа. Бид их олон янзаар үзсэн. Сая Нямаагийн Энхболд гишүүний хэлсэнтэй манай ажлын дэд хэсэг, ажлын хэсэг санаа бол нэг байгаа.

Яавал хурлаа чадваржуулах вэ, чадавхтай байх вэ гэдэг ийм асуудал байгаа. Зүгээр яг одоогийн хуулийн хувьд гуравны нэг хүртэлх хувь нь Төрийн албаны хуульд заасны дагуу төрийн захиргааны албан тушаал эрхэлж болно гэсэн энэ заалт.

Энэ заалт ер нь уг утгаараа бол их айхтар маргаантай ийм заалт байдаг. Үүнийг хэрэгжүүлэх гээд үзэхээр бас түвэгтэй асуудлууд нэлээн байна. Жишээлэх юм бол дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга хүн дүүргийнхээ иргэдийн Хурлын төлөөлөгч болчихоор нөгөө иргэдийн Хурлын хийдэг функцүүдийг яах вэ гэдэг. Нөгөө Засаг даргынхаа үйл ажиллагаанд хяналт тавьдаг, тайлагнадаг энэ механизм дээрээ яаж ашиг сонирхлын зөрчилгүйгээр оролцох вэ ч гэдэг юм уу.

Гэх мэтчилэнгийн энэ өөрөө нэлээн тийм хүндрэлтэй асуудал бас байдаг л даа. Зүгээр. Ажлын дэд хэсэг болон ажлын хэсэг дээр юу гэж ярьсан бэ гэхээр ядаж хамгийн наад зах нь хүн хүчний хувьд сумын хурлын хувьд арай өөр юм байна. Тийм учраас аймаг, нийслэл, дүүргийн хувьд үүнийг зөвшөөрч болохгүй. Зөвхөн суман дээр үүнийгээ зөвшөөрөөд явъя гэсэн ийм байдлаар л ярилцсан байгаа юм.

**Л.Энх-Амгалан:** С.Амарсайхан гишүүн.

**С.Амарсайхан:** Аймаг, нийслэл, сум, дүүрэг хөгждөггүй. Боловсон хүчин чадавхждаггүй. Улс төрждөг, талцдаг, туйлширдаг гол шалтгаан бол ерөөсөө энэ төлөөлөгчид ажил эрхэлдэг байдал. Төрийн захиргаа нь ч бай, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд ч бай улс төрийн албан тушаалаас бусад төлөөлөгчид ажил хашдаг болсноос хойш ерөөсөө энэ орон нутаг хөгжих асуудал хойшоо татагдаж байгаа.

Тэгэхээр ажлын хэсэг дээр би хатуу байр сууриа илэрхийлсэн. Санал зөрөлдөөн зөндөө гарсан. Энэ төлөөлөгчдийг ажил хийдгийг болиулъя. Зөвхөн улс төрийн албан тушаалтан. Одоо Засаг дарга байна

уу, Засаг даргын орлогчид нь байвал хашдаг байг. Бусад нь тэр төлөөлөгчийнхөө үндсэн чиг үүрэг буюу орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлдог, хяналтаа тавьдаг, төсвөө баталдаг ийм гурван үндсэн чиг үүргээ хэрэгжүүлдэг байя гэж.

Төсвөө батална, бодлогоо тодорхойлно. Тэгээд өөрсдөө төсвөө захиран зарцуулна гээд ашиг сонирхлын зөрчилтэй. Авлига, хээл хахуулийн тухай хуулийг зөрчсөн. Тэгээд ажил явдаггүй. Гэтэл яг нөгөө салбараар мэргэших ёстой орон нутгийн хүмүүс нь мэргэшиж чаддаггүй. Сонгуулийн 4 жил болдог. Нэг төлөөлөгч алба хашиж байгаад жишээ нь орон нутгийн өмчит нэг байгууллага. Тэгээд одоо инженерингийн байгууламж ч гэдэг юм уу бусад хэлбэрийн аж ахуйн нэгжийг эрхэлж байгаад, одоо ажлыг нь хашиж байгаад алга болдог.

Дахиад нөгөө салбар нь бэлтгэгдсэн боловсон хүчин байхгүй унадаг. Энэ хэрээрээ хот, тосгоны хөгжлийн бодлого алдагддаг ийм харш зүйл яваад байгаа юм.

Тийм учраас аймаг, нийслэл, дүүрэг дээр сум, орон нутагт төлөөлөгчид ямар ч түвшинд төрийн захиргаа, нийтийн үйлчилгээ, бусад хэлбэрийн ажил эрхэлдэг байдлыг таслан зогсооё гэж байгаа юм.

Энэ дээр нэлээн нухацтай үзэхгүй бол энэ одоо ингээд бүх шатандаа учир нь олдохгүй ийм асуудал явсаар байгаад эцэст нь хариуцлага тооцдог хүн байхгүй. Явж явж улсаараа боловсон хүчний чадавх нь.../минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Санал хураалт.

Төрийн албаны хуулиасаа буцалт хийж байна гээд байгаа юм л даа. Ухралт хийж байна гээд байгаа юм л даа.

11 гишүүн оролцож, 4 гишүүн зөвшөөрч, 36.4 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Өргөн баригдсан төслөөрөө үлдсэн гэсэн үг. Тийм ээ.

Төслийн 41 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

42 байгаа юм байна шүү. Тэр чинь. Тийм. 42 юм байна.

Төслийн 42 дугаар зүйл дээр саналтай гишүүд байгаа юм байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 42 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“42 дугаар зүйл.Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

42.1.Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

42.1.1.Төлөөлөгчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашиглах;

42.1.2.өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх.

*Тайлбар: Энэ заалтыг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн мөрдөнө.”*

Санал гаргасан Ажлын хэсэг.

Одоо бол энэ хуулиар байгаа шүү дээ. Тийм ээ. Санал хураалт.

Давхар дэвшихгүй. Нэг л хурлын төлөөлөгч байа гэж байгаа юм. Одоо бол аймаг, сумынх чинь хамт байгаад байгаа шүү дээ.

11 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 81.8 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 43 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 44 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 45 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 46 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 47 дугаар зүйл дээр зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна.

Төслийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.6.Улс төрийн нам, эвсэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтцэд аливаа хэлбэрээр зохион байгуулалтын нэгж байгуулахгүй.

*Тайлбар: Энэ хэсгийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн мөрдөнө.”*

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

11 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 72.7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 48 дугаар зүйл дээр ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа юм байна.

Төслийн 48 дугаар зүйлийн 48.1.4, 48.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“48.1.4.ээлжит сонгуулийн дүнг өргөн мэдүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор тухайн шатны сонгуулийн хороо иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааныг зарлан хуралдуулна. Анхдугаар хуралдааныг хуралдаанд хүрэлцэн ирсэн насаар хамгийн ахмад сонгогдсон төлөөлөгч даргална;

48.1.5.анхдугаар хуралдаанаас бусад хуралдааныг тухайн Хурлын дарга хуралдаан эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулна. Хуралдааныг Хурлын дарга, түүний эзгүйд Хурлын даргын санал болгосноор төлөөлөгчдийн аль нэг нь удирдана;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ их тодорхой болгож өгч байгаа юм байна. Иргэдийн Хурал байгуулагдах хугацааг. Тийм. Одоо бол хуралдаанаа зарлахгүй алга болчихоод байгаа шүү дээ. Тийм ээ.

11 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 63.6 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 49 дүгээр зүйл дээр саналтай гишүүд алга байна.

Төслийн 50 дугаар зүйл дээр саналтай гишүүд алга байна.

Төслийн 51 дүгээр зүйл дээр саналтай гишүүд алга байна.

Төслийн 52 дугаар зүйл дээр ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа юм байна.

Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Тухайн Хурал өөрийнх нь чиг үүрэг, бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжүүлэх боломжгүй, санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга өөрийн санаачилгаар, эсхүл дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдын даалгаснаар холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Энэ жаахан тийм субъектив юм орох вий дээ. Зүгээр хэрэгжүүлэх боломжгүй гээд л хэлчихвэл одоо хэн боломжгүй. Нэг хэсэг нь боломжтой гэж үзээд оруулаад ирдэг. Засаг дарга наадах чинь боломжгүй гээд л хэлчихвэл бас нэг тийм субъектив хандлагууд болоод байх вий дээ. Үүнийг нь жаахан тодорхой болгож өгөхгүй бол.

Санхүүгийн болон бусад эх үүсвэрийг жаахан найруулмаар юм байна. Эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол гэдэг нь ойлгомжтой. Энэ ч боломжгүй юм байна гээд.

Тэгэхээр энэ боломжгүй гэдгийг нь яахгүй бол нэг тийм хувь хүнээс шалтгаалсан субъектив шийдвэр гаргадаг юм болох вий дээ л гэж санаа зовж байгаа юм. Дараа нь найруулгынхаа юм нь дээр жаахан тодруулж харах нь зүйтэй болов уу гэж санал хэлж байна.

**Л.Энх-Амгалан:** Дараагийн хэлэлцүүлэгт энэ найруулгыг гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна.

Санал хураалт.

11 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 81.8 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 53 дугаар зүйл дээр саналтай гишүүд байгаа юм байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“53.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулсан зохицуулах үүрэг бүхий 5-7 хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд ээ.

11 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 81.8 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 53 дугаар зүйл дээр санал байгаа юм байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

11 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 72.7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 54 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 55 дугаар зүйл дээр саналтай гишүүд байгаа юм байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 55 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“55 дугаар зүйл.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгох**

55.1.Сонгуулийн дүнгээр байгуулагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаар Хурлын даргыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

55.2.Тухайн Хурлын төлөөлөгч Хурлын даргад өөрийн болон бусад төлөөлөгчийн нэр дэвшүүлэх эрхтэй. Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад нам, эвслийн бүлэг нэр дэвшүүлж болно.

55.3.Хурлын даргыг сонгох асуудлаар нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхын санал авсан хүнийг Хурлын даргаар сонгогдсонд тооцно.

55.4.Нэр дэвшигчийн аль нь ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг хоёр дахь санал хураалтад оруулах бөгөөд тэдгээрийн хэн нь ч олонхын санал аваагүй бол энэ зүйлд заасан журмаар Хурлын даргад дахин нэр дэвшүүлнэ.

55.5.Хурлын төлөөлөгчид санал хураалтад оролцохдоо зөвхөн нэг хүний төлөө санал өгөх бөгөөд нэр дэвшигч өөрөө санал хураалтад оролцох эрхгүй.

55.6.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга орон тооны байна.

55.7.Хурлын даргыг нөхөн сонгоход энэ зүйлд заасан журмыг баримтална.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Эрхтэй. Нэгдүгээрт эрхтэй шүү. Та буруу уншлаа. Эрхгүй гээд. “55.6 дээр нэр дэвшигч өөрөө санал хураалтад оролцох эрхтэй” гэдгийг нь “эрхгүй” гээд хэлсэн. Эрхтэй.

Хоёрт, энэ 55.2-ын аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад нам, эвслийн бүлэг нэр дэвшүүлж болно гэдгийг нөгөө 2024 оны сонгуулийнхаа юмтай яаж уялдуулах вэ?

Эсвэл үүнийг нь тусдаа заалт болгоод энэ заалт 2024 оноос хойш хэрэгжихгүй ч гэдэг юм уу тийм тайлбар хэлэхгүй бол. Тийм л дээ. Тэгэхдээ 2024 онд чинь бүлэг гэж юм байхгүй болно шүү дээ. Аймаг, нийслэл, дүүрэг нь үү. Аан. За тийм байна. Уучлаарай. Би тэрийг нь харсангүй.

**Л.Энх-Амгалан:** Тэр нэр дэвшигч өөрөө санал хураалтад оролцох эрхтэй шүү. Тийм ээ. Ингээд санал хураалт.

11 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 63.6 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 56 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 57 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 58 дугаар зүйл дээр саналтай гишүүд байгаа юм байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншъя.

Төслийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“58.5.Засаг даргад нэр дэвшүүлэх ажиллагааг дараах журмаар явуулна:

58.5.1.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, сонгуулийн дүнгээр олонхын суудал авсан нам, эвслийн бүлэг, иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтарч энэ хуулийн 58.3, 58.4-т заасан шаардлага хангасан хүнийг нэр дэвшүүлэхээ санал гаргана.

Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 58.3-т заасан шаардлага хангасан хүнийг тухайн Хуралд санал болгож болно;

58.5.2.энэ хуулийн 58.5.1-д заасан хүний талаар санал хураалт явуулж, Хуралд оролцсон иргэдийн, түүнчлэн нийт төлөөлөгчдийн олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлнэ;

58.5.3.хэрэв санал хураалтаар хэн ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүний талаар дахин санал хурааж олонхын санал авсан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлнэ;

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

11 гишүүн оролцож, 7 гишүүн зөвшөөрч, 63.6 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Энэ дээр зүйл дээр бас Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасан юм байна. Уншъя.

Саяын ажлын хэсгийн санал дэмжигдсэн учраас энэ санал уг нь хураалт хийхгүй юм байна.

“Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 58.3-т заасан шаардлага хангасан хүнийг тухайн Хуралд санал болгож болно.” гэснийг төслөөс хасах.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Б.Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайд энэ хуулийн 58.3-т заасан шаардлага хангасан хүнийг тухайн Хуралд санал болгож болно гэсэн. Нутгийн өөрөө удирдах байгууллага болох иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд халдаж байгаа ийм заалт байна.

Ер нь Үндсэн хуулийн 59.1-д Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжүүлнэ гэж байгаа.

Үндсэн хууль дээр хослуулах үндсэн дээр хэрэгжүүлнэ гэсэн энэ заалтыг одоо ингээд хольсон болгоод ингээд. Өөрөөр хэлбэл энэ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд халдах ийм замаар асуудалд хандаад явж байна.

Тэгэхээр Ерөнхий сайд гэдгээ аль нэгэн намынх дарга байж байгаа. Тэгэхээр энэ намын шийдвэр энэ нутгийн өөрөө удирдах ёсны энэ



байгууллагын үйл ажиллагаанд шууд халдаж орохоор ийм нөхцөл байдалд орж байгаа.

Тэгэхээр бид энэ сонгуулийн өмнө, орон нутгийн сонгуулийн өмнө энэ хуулийг завсарлага авч хойшлуулсан. Хэрвээ энэ хууль сонгуулийн өмнө батлагдсан бол энэ бол өнөөдрийн Монгол Ардын Намд маш хортойгоор хэрэгжих байсан юм. Өөрөөр хэлбэл одоо жишээ нь 8 аймаг дээр Ардчилсан намынхан ялсан байгаа.

Энэ 8 аймаг дээр жишээ нь манай намынхан Ерөнхий сайдын санал болгосон хүнийг үл тоон дараагийнхаа хүнийг, өөрсдийнхөө хүмүүсийг оруулаад явчихна. Хамгийн гол нь Монгол Ардын Намын ялсан тэр аймгууд дээр Ерөнхий сайдын сонирхол орж ирээд энэ нь нутгийн иргэд энэ хүнээр Засаг дарга болгоно гэсэн тэр зүйлийг нь Ерөнхий сайд нь шийддэг ийм л болж хувирах байсан юм. Өөрөөр хэлбэл энэ бол өнөөдрийн Монгол Ардын Намд маш хортой ийм шийдвэр болох байсан байхгүй юу. /минут дуусав/

**Л.Энх-Амгалан:** Та саналаа татах уу? Сая тайлбараа хэллээ шүү дээ. Одоо ингээд хэрэгжих хугацаа нь 2024 он.

1 минут. Б.Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр ийм хортой зүйл болох байсан юм. Тийм учраас энэ заалт чинь өөрөө Үндсэн хуулийн зөрчил рүү хүрч байгаа.

Тийм учраас Үндсэн хуулийн цэцэд би яг өөрийн биеэр хандаж энэ асуудал дээр батлагдах юм бол энэ асуудлаар ингээд Үндсэн хуулийн цэцэд өгнө.

Ер нь зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэн заавал хураалгах ёстой. Тийм учраас энэ саналыг хураалгаж өгөөч ээ гэж хүсэж байна.

**Л.Энх-Амгалан:** Санал хураалт. Хажуугийн санал гэж хурааж болох юм байна. Тийм.

11 гишүүн оролцож, 2 гишүүн зөвшөөрч, 18.2 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Төслийн 59 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 60 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 61 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 62 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 63 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 64 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 65 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 66 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 67 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 68 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 69 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 70 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 71 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 72 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 73 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 74 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байгаа юм байна.

Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 74 дүгээр зүйлийн 74.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“74.1.2.шаардлагатай гэж үзвэл харьяалагдах нутаг дэвсгэрийн салбарын болон салбарын хоорондын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхдээ тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзан Засаг даргын саналыг тусган хамтарсан шийдвэр гаргаж, биелэлтийг зохион байгуулах;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд ээ.

11 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 72.7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 75 дугаар зүйл дээр санал байгаа юм байна. Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 75 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“75 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын харилцаа**

75.1.Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор нэгж хоорондоо доор дурдсан хэлбэрээр харилцана:

75.1.1.бодлого, үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох;

75.1.2.нийтийн эрх зүйн гэрээ байгуулах;

75.1.3.харилцан туслалцаа үзүүлэх;

75.1.4.төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх;

75.1.5.харилцан туршлага солилцох;

75.1.6.хууль тогтоомжид заасан бусад хэлбэрээр харилцах.

75.2.Энэ хуулийн 75.1-д заасан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх явцад Засаг хооронд үүссэн маргааныг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол дээд шатны Засаг дарга, эсхүл Ерөнхий сайд шийдвэрлэнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 66.7 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Төслийн 76 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 77 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 78 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 79 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 80 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 81 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Найруулгын саналаар одоо санал хураалт хийнэ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Найруулгын саналаар санал хураалт хийнэ. Найруулгыг нэг уншчихна шүү дээ.

Найруулгын санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “бүхий” гэсний дараа “нийтлэг” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “хэрэгжүүлэх” гэсний дараа “үйл ажиллагааг дэмжих” гэж, 60 дугаар зүйлийн 60.1.10 дахь заалтын “ашиглах,” гэсний дараа “хууль” гэж, 62 дугаар зүйлийн 62.1.20 дахь заалтын “аймаг” гэсний өмнө, 65 дугаар зүйлийн 65.1.15 дахь заалтын “нийслэл” гэсний өмнө “энэ хуульд заасан үндэслэлээр” гэж, 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн “нутаг дэвсгэрийн” гэсний дараа “иргэн,” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “дамжуулж” гэснийг “уламжлан” гэж, 2 дугаар зүйлийн “нэгжийн” гэснийг “нэгж, түүний удирдлагын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “засаг захиргааны” гэснийг “хуульд заасан” гэж, мөн зүйлийн 11.2 дахь хэсгийн “хорооны иргэдийн Нийтийн Хурал” гэснийг “дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтын “зоригийн илэрхийлэл байх,” гэснийг “зоригийг илэрхийлж,” гэж, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “нийгмийн” гэснийг “хуульд заасан” гэж, 16 дугаар зүйлийн гарчгийн “төсвийн эрх мэдэл” гэснийг “төсөв” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь

хэсгийн “тогтооно” гэснийг “тогтоож, журмын хэрэгжилтэд хяналт тавина.” гэж, 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн “үйл ажиллагаатай холбоотой” гэснийг “үйл ажиллагааны зохион байгуулалтын” гэж, 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсгийн “мөрдөгдөнө” гэснийг “хэвээр үлдээнэ” гэж, 61 дүгээр зүйлийн 61.1.8 дахь заалтын “Засгийн газрын” гэснийг “төрийн” гэж, мөн зүйлийн 61.1.9 дэх заалтын “20 дугаар зүйлийн 20.6-д” гэснийг “20 дугаар зүйлд” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “талаар” гэснийг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсгийн “аравт,” гэснийг тус тус, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 37 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд” гэснийг, 54 дүгээр зүйлийн 54.1.6 дахь заалтын “асуудлыг Хуралд оруулж шийдвэрлүүлэх” гэснийг, 58 дугаар зүйлийн 58.8 дахь хэсгийн “иргэдийн” гэснийг, 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсгийн “Засаг даргыг” гэснийг, 74 дүгээр зүйлийн 74.1.4 дэх заалтын “хүч,” гэснийг, 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгийн “төв” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 10 гишүүн зөвшөөрч, 83.3 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Одоо дагасан хуулийн зүйл бүрээр. Тийм ээ. Зүйл бүрээр санал хураалт хийнэ.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 8 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо Монгол Улсын татварын ерөнхий хууль өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл бүрээр санал хураалт хийнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Одоо Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх

журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу?

Ажлын хэсгийн санал байгаа юм байна. Тийм ээ. Энэ чинь нөгөө хоёр дахь уу?

Хоёр. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Хотын албан татварын тухай анхдагч хуулийн төслийг 2021 оны эхний хагаст багтаан боловсруулж, өргөн мэдүүлэх;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн саналын томъёоллоор санал хураалт хийе. Санал хураалт.

Найруулгыг бас жаахан анхаарах ёстой юм байна шүү. Тийм ээ.

12 гишүүн оролцож, 8 гишүүн зөвшөөрч, 66.7 хувийн саналаар өмнөх санал хураалт хүчингүй боллоо.

Тийм учраас дахин санал хураалт хийе. Санал хураалт. Гишүүд ээ.

12 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 75.0 хувийн саналаар энэ санал дэмжигдэж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүйд тооцсон тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар гишүүн танилцуулна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.